

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /COVID-19/-ЫН
ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

**Ч. Энхбаяр /PhD, профессор/
Э. Тод-Од /MAS, докторант/
Д. Лхагва-Очир
Н. Тэргэл
А. Мөнх-Эрдэнэ
Г. Батбилэг**

ГАРЧИГ

ХУРААНГУЙ.....	3
ЕРӨНХИЙ ТОЙМ	4
1. МОНГОЛ УЛС	5
1.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	5
1.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ	5
1.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ	7
1.4. БИЗНЕС, ЭДИЙН ЗАСАГ	7
1.4.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн	7
1.4.2. Төсвийн бодлого	10
1.4.3. Мөнгөний бодлого	10
1.4.4. Эдийн засгийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	11
2. АЗИ.....	12
2.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	12
2.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ	12
2.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ	13
2.3.1. Хууль, эрх зүй:	13
2.3.2. Сонгууль:	14
2.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ	14
2.4.1. Төсвийн бодлого:	16
2.4.2. Мөнгөний бодлого:	18
2.4.3. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн бодлого.....	21
3. ЕВРОП	25
3.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	25
3.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ	25
3.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ	28
3.3.1. Хууль эрх зүй:	28
3.3.2. Сонгууль:	29
3.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ	29
3.4.1. Төсвийн бодлого	29
3.4.2. Мөнгөний бодлого	32
4. ХОЙД АМЕРИК.....	34
4.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	34
4.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ	35
4.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ	38
4.3.1. Төсвийн бодлого:	38
4.3.2. Мөнгөний бодлого:	39
4.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ	40
ХАРЬЦУУЛАЛТ БА ДҮГНЭЛТ	42
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	47

ХУРААНГУЙ

Дэлхий дахиныг донсолгосон коронавируст цар тахал /COVID-19/-ын тархалтыг албан ёсоор 2019 оны 12 сарын 8-наас эхэлсэн гэж үздэг бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн 216 орныг хамраад байна.

COVID 19 нь дэлхийн улс орнуудын засгийн газрыг эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн салбарын аль ч түвшинд тодорхойгүй байдалд ажиллахад хүргэсэн бөгөөд тэдний онцгой нөхцөлд хэр шуурхай хариу үйлдэл үзүүлэх, тулгамдсан асуудлыг хэрхэн ухаалгаар шийдвэрлэх чадамжийг шалгасан явдал болж байна.

Манай улсын Засгийн газар ч энэхүү хүнд сорилттой тулгарсан бөгөөд шуурхай хариу арга хэмжээг авч чадсаны үр дүнд хэдийгээр халдвар зөөвөрлөгдөн орж ирсэн ч дотооддоо алдалгүй 8 сар тэсч чадсан юм. Харин өнөөдөр байдал өөрчлөгдөж дотооддоо нэгэнт халдварыг алдсан бөгөөд цаашид түүнийг богино хугацаанд хумих, эдийн засгаа аль болох эрсдэл багатайгаар авч гарах зэрэг асуудалтай шууд нүүр туллаа.

Энэхүү судалгааг бид богино хугацаанд хийсэн бөгөөд зарим орны жишээн дээр дэлхийн улс орнуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээг: ерөнхий нөхцөл байдал; эрүүл мэнд, онцгой байдал; хууль эрх зүй, улс төр, нийгэм; бизнес, эдийн засаг гэсэн чиглэлүүдээр авч үзэн зэрэгцүүлж харахыг хичээлээ. Судалгаанд хүчирхэг эдийн засаг болон үүссэн нөхцөл байдалд түргэн шуурхай, уян хатан хандсан зэргийг харгалзан улсуудыг сонгож, хамгийн түгээмэл байгаа мэдээллүүдийг ашиглав.


Дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа тул ижил төстэй хувилбаруудыг нэгтгэн дүгнэх боломж өнөөгийн байдлаар хомс байна. Иймд бид судлаачдад өөрсдийн чиглэл бүрээр ажиллахад нь нэмэр болох зорилгоор ерөнхий тойм судалгааг хийлээ. Энэ нь тэдний цаашдын нарийвчилсан судалгаанд өчүүхэн ч гэсэн тус болох болов уу гэж найдаж байна.

Бидний хувьд ч энэхүү тойм судалгаагаа үргэлжлүүлэн нарийвчилсан чиглэлүүдээр хийхээр ажиллаж байгаа болно.

ЕРӨНХИЙ ТОЙМ

Дэлхийн дахинд COVID-19 цар тахал дэгдсэнээс хойш өнөөг хүртэл /2020.11.17/ хурдацтай тархсаар нийт 55,558,120 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүний 1,320,148 нь нас баралтын тохиолдол /нас баралтын хувь 2.4%/ байсан бол 38,584,824 хүн эмчлүүлж эдгэрсэн байна /эдгэрэлтийн хувь 69.4%/. Зарим орны тархалтын нийт тохиолдлыг график 1-т харуулав.

График 1. COVID-19 цар тахлын нийт тохиолдлууд зарим улс орноор, мянган хүн




Вирусийн анхны голомт болох БНХАУ-д сүүлийн байдлаар нийт 92,476,000 тохиолдол бүртгэгдсэн. Хятад улс нэг өдрийн дотор хамгийн ихдээ 15,152 тохиолдол /2020.02.13/ шинээр бүртгэж байжээ.

Харин Франц, Испани, Канад, Их Британи тэргүүтэй улс орнууд COVID-19 –н халдварын эсрэг шат дараатайгаар арга хэмжээ авсны үр дүнд халдварыг тогтоон барьж чадсан хэдий ч дараа нь хөл хориог цуцалж, хязгаарлалтуудыг сулруулсаны улмаас эргээд тархалт газар авч хоёр дахь давлагаанд өртөөд байна.

АНУ-н хувьд засгийн газар, удирдах байгууллагууд COVID-19 вирусийн эсрэг бусад улс орны адилаар тэмцэж байгаа хэдий ч үр дүн муутай байна. 2020 оны 4-р сараас эхэлсэн хурдацтай өсөлт үргэлжилсээр байгаа бөгөөд энэ нь ард иргэдийн жагсаал, цуглаан, буруутай үйл ажиллагаатай холбоотой. Сүүлийн байдлаар АНУ –д нийт 10,796,432 вирусийн тохиолдол бүртгэгдсэн байна.

График 2. Эдийн засгийн өсөлт, 2020 оны III улирлын байдлаар



Эх сурвалж: OECD, <https://stats.oecd.org/index.aspx?queryid=350#>

Хатуу чанга хөл хорионы дүнд вирусийн тархалтыг тогтоож чадсан БНХАУ –ын эдийн засаг сэргэж бодит үйлдвэрлэл 2020 оны III улирлын байдлаар 4.9% -р өсчээ. Харин АНУ, Франц, Испани зэрэг бусад улс орон хямралтай нүүр тулсаар байна.

1. МОНГОЛ УЛС

1.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

2019 оны 12 сард БНХАУ-д шинэ коронавирус дэгдэж, тухайн бүс нутагт хөл хорио тогтоож эхэлсэнтэй холбоотойгоор хил зэргэлдээ орших Монгол Улсын хувьд шинэ COVID 19-ийн халдварын болзошгүй эрсдэл нэмэгдэж, олны анхаарлыг татах болсон. Үүнтэй холбогдуулан 2020.01.24-ний өдөр Улсын онцгой комисс хуралдаж, түүнээс хойш УИХ, Засгийн газартай хамтран шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд :

- ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2020.01.27-с эхлэн 2020 оны хаврын хичээлийн жилийг дуустал түр хугацаанд хаасан бөгөөд энэ хугацаанд цахимаар хичээл орсон. Харин 2020 оны намрын хичээлийн жил 09-р сараас эхлэн танхимаар хичээллэж эхэлсэн боловч коронавирусыг дотооддоо алдсантай холбоотойгоор 2020.11.11-**2020.12.01**-ний өдрийг дуустал бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр зогсоосон;
- Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаагаар хязгаарласан;
- Уламжлалт сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэхийг уриалж, олныг хамарсан зохион байгуулалттай золголт хийхийг хориглосон;
- МУ, БНХАУ-ын хилийн бүх боомтын хөдөлгөөнийг 2020.02.01-2020.04.30-ны өдөр хүртэл түр хугацаанд зогсоосон;
- Бусад улсын иргэдийн хөдөлгөөн болон ОХУ-тай хиллэх хилийн боомтын бүх хөдөлгөөнийг шат дараатайгаар 2020.04.30-ны өдөр хүртэл түр хугацаанд зогсоосон;
- Улс, хот хоорондын зорчигч тээвэр, суудлын галт тэрэг болон хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020.02.23-2020.03.03, 2020.03.10-2020.03.16 болон 2020.11.11-**2020.12.01**-ний өдрийн хооронд түр зогсоосон;
- Хэдийгээр COVID 19-ийн эрсдэлтэй, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн ч 2020.06.24-ний өдөр УИХ-н ээлжит сонгууль, 2020.07 сарын 02-05-ны өдрүүдэд ЭЕШ-ыг тус тус зохион байгуулсан;
- Мөн хүүхдийн тоглоомын газар, баар, биллъярд, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг 2020.07.01-с эхлэн шат дараатайгаар нээж эхэлсэн.

1.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ

Манай улсын хувьд **2020.11.17**-ны өдрийн байдлаар, коронавируст халдварын нийт батлагдсан тохиолдол 434 болсон байна.

- Нийт батлагдсан тохиолдлын 75.5 хувь буюу 328 нь эдгэрсэн /үүнээс 16 нь хяналтад байгаа, 2 нь гэрийн ажиглалтад, 310 нь ажиглалтаас гарсан/, 100 хүн эмчлүүлж байгаа /үүнээс биеийн байдлаар нь авч үзвэл 77 нь хөнгөн, 21 нь хүндэвтэр, 2 нь хүнд/ үлдсэн 5 нь гадаад иргэн нутаг буцсан байна.
- Батлагдсан тохиолдлыг хүйсийн хувьд авч үзвэл, 290 нь эрэгтэй, үлдсэн 144 нь эмэгтэй байна.
- Харин насны бүлгийн хувьд авч үзвэл, 20-24 насныхан хамгийн өндөр байна.

Хүснэгт 1 . 2020.11.17-ны өдрийн байдлаар, коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээ

Батлагдсан тохиолдлын тоо		434
Эдгэрсэн /328/	Хяналтад байгаа	16
	Гэрийн ажиглалтанд	2

	Ажиглалтаас гарсан	310
Эмчлэгдэж байгаа /100/	Хөнгөн	77
	Хүндэвтэр	21
	Хүнд	2
Нутаг буцсан гадаад иргэн /өөрийн хүсэлтээр/		5

Шинжилгээ хийсэн тоо		101,970
Тусгаарласан хүний тоо	Нийт	33,113
	Одоо байгаа	2,259

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, <https://covid19.mohs.mn/>

Засгийн газраас эрүүл мэндийн нэмэлт зардалд 17 тэрбум төгрөгийг /ДНБ-ний 0.04 хувь/ баталж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, эмнэлгийн хангамж, эмнэлгийн ажилтнуудын илүү цагийн цалин хөлсийг санхүүжүүлэхэд хуваарилсан. Энэхүү арга хэмжээг Засгийн газрын нөөц сангаас татан төвлөрүүлэх замаар санхүүжүүлсэн байна.

Эрүүл мэндийн яамнаас коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ард иргэдийн дунд тогтмол зөвлөмж, мэдээллийг хүргэж ажилласан бөгөөд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурьдвал:

- Сүүлийн 14 хоногийн хугацаанд гадны улсад оршин суудаг, аялсан, богино хугацаагаар зорчсон өгүүлэмжтэй, халуурах ба ханиах, амьсгал давхцах зэрэг шинж тэмдэг илэрсэн мөн коронавируст халдварын батлагдсан эсвэл магадлалтай тохиолдолтой ойрын хавьтал болсон хүнийг ХӨСҮТ болон эрүүл мэндийн байгууллагад 14 хоног тусгаарлан хянах;
- Хилээр орж байгаа зорчигчдыг 21 хоногийн хугацаанд тусгаарлаж, түүний дараагаар нэмэлт 14 хоног гэртээ байж, өөрийгөө тусгаарлах;
- “Маскаа зүүцгээе” аяныг 2020.04.13-2020.05.31-ний хооронд зохион байгуулсан;
- “Маскаа зүүцгээе, Гараа угаая” 2 дугаар аяныг 2020.10.05-2020.12.31-ний өдрийг хүртэл зохион байгуулж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын онцгой комисс, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2020.02.13-2020.11.11-ний өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн бол улсын хэмжээнд 2020.11.12-**2020.12.01**-ний өдөр хүртэл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хатуу хөл хорионы дэглэм тогтоолоо.

- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн үеэс эхлэн хилийн боомтоор нэвтрэх ард иргэдийн хөдөлгөөнийг хязгаарласан бөгөөд ачаа тээврийн үйл ажиллагааг хяналт шалгалтын хүрээнд дамжин өнгөрүүлж ирсэн. Харин Засгийн газрын 2020.11.11-ний өдрийн ээлжит хуралдаанаар дараах шийдвэрийг гаргасан. Үүнд: Монгол Улс, ОХУ-ын хилийн Алтанбулаг боомтоор ачаа тээвэрлэхийг 2020.11.16- 2021.01. 18-ны өдрийг хүртэл зогсоосон. Цагааннуур боомт /Баян-Өлгий/-ыг 2020.11.23-ны өдрөөс эхлэн сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногт ажиллуулж зөвхөн шатахуун тээврийн машин нэвтрүүлэх, Тэс /Увс/, Арцсуурь /Завхан/, Ханх /Хөвсгөл/, Ульхан /Дорнод/, Эрэнцав /Дорнод/ авто замын боомтыг 2020.11.16-ны өдрөөс, Боршоо /Увс/ боомтыг 2020.11.23-ны өдрөөс хаахаар шийдвэрлэсэн байна.
- Бүх нийтийн бэлэн байдлын үед хүнсний дэлгүүр, хүнсний зах, ШТС, цахилгаан дулаан, түлш хангамж, эмнэлэг, эмийн сан, усан хангамж, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны байгууллагууд, буяны үйл ажиллагаа, хот хоорондын хүнсний тээврээс бусад салбарын үйл ажиллагааг

хязгаарласан байна. Мөн дээрх хугацаанд нийтийн тээвэр зөвхөн 06.00-10.00, 17.00-21.00 цагийн хооронд буюу ажил эхлэх, тарах үед ард иргэдэд үйлчилж байна.

1.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ

Улсын Их Хурал /УИХ/ 2020.04.19-ний өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг хэлэлцэн баталсан. Уг хуулинд УИХ, ЗГ, УОК, Төрийн бусад байгууллага, Төв банк болон арилжааны банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан бөгөөд хуулийн үйлчлэх хугацааг 2020.12.31-ний өдрийг хүртэл тогтоосон байна.

Хуулийн хүрээнд ЗГ-с авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурьдвал:

- цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;
- нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг /цагаан сар г.м/ тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд болон зарим нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлах;
- бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах;
- өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх;
- шашны байгууллагын шашин номын хурал, цуглааныг олон нийтийг биечлэн хамруулан зохион байгуулахыг тодорхой хугацаагаар зогсоох.

Хуулийн хүрээнд төв банк болон арилжааны банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурьдвал:


- Иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх;
- Ипотекийн зээл болон хэрэглээний зээлийн хувьд эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 хүртэлх сарын хугацаагаар сунгах;
- Ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувиас 6 хувь болгон бууруулсан гэх мэт.

1.4. БИЗНЕС, ЭДИЙН ЗАСАГ

1.4.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2020 оны III улирлын байдлаар, ДНБ /2010 оны зэрэгцүүлэх үнээр, үйлдвэрлэлийн аргаар, өссөн дүнгээр/ 12.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 их наяд төгрөг буюу 7.3 хувиар буураад байна. Уг бууралтад уул уурхай, олборлолтын салбар 595.5 тэрбум төгрөг /20.7%/, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 212.3 тэрбум төгрөг /24.8%/, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 207.3 тэрбум төгрөг /13.1%/, бүтээгдэхүүний цэвэр татвар 146.6 тэрбум төгрөг /8.4%/ тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

График 3. МУ-ын ДНБ, их наяд төгрөг




Эх сурвалж: YCX, <https://1212.mn/>

2020.06.01-ний өдрийн байдлаар Азийн Хөгжлийн Банкнаас гаргасан коронавируст халдварын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн таамаглал дараах байдалтай байна.

- Олон улсын хэмжээнд цар тахал тархснаар Монгол Улсын эдийн засагт үзүүлэх богино хугацааны сөрөг нөлөө нь 530 сая ам.доллар буюу ДНБ-ий 4.1 хувь байна. Харин урт хугацааны сөрөг нөлөө нь 783 сая ам.доллар буюу ДНБ-ий 6.0 хувь байна. Үүнд уул уурхай, олборлолт, худалдаа, нийтийн үйлчилгээний салбарын бууралт голлон нөлөөлөхөөр байна.

График 4. Цар тахлын үед глобал эдийн засгийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Азийн хөгжлийн банк
Жич: ДНБ-ий алдагдал /сая ам.доллараар/

Хүснэгт 2. Цар тахлын үед глобал эдийн засгийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө

Цар тахлын үед глобал эдийн засгийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө									
Салбар	Тархалтыг богино хугацаанд хумиж чадвал		Тархалт урт хугацаанд үргэлжилбэл		Суваг	Тархалтыг богино хугацаанд хумиж чадвал		Тархалт урт хугацаанд үргэлжилбэл	
	<i>Салбарын ДНБ-ий хувиар</i>	<i>Сая ам.доллараар</i>	<i>Салбарын ДНБ-ий хувиар</i>	<i>Сая ам.доллараар</i>		<i>Салбарын ДНБ-ий хувиар</i>	<i>Сая ам.доллараар</i>	<i>Салбарын ДНБ-ий хувиар</i>	<i>Сая ам.доллараар</i>
Хөдөө аж ахуй, уул уурхай	-4.1	-\$209	-6.2	-\$312	Дэлхийн үр дагаврын халил /Аялал жуулчлалаас бусад/	-2.5	-\$330	-3.8	-\$494
Бизнес, худалдаа, хувийн болон нийтийн үйлчилгээ	-2.2	-\$108	-3.3	-\$160		-1.5	-\$200	-2.2	-\$289
Хүнд, хөнгөн үйлдвэрлэл, ус, цахилгаан, дулаан, барилга	-1.9	-\$41	-2.8	-\$60	Олон улсын аялал жуулчлалын уналт	0.0	\$0	0.0	\$0
Зочид буудал, ресторан, үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-20.4	-\$62	-29.5	-\$89	Дотоод эрэлтийн уналт	0.0	\$0	0.0	\$0
Тээврийн үйлчилгээ	-16.2	-\$111	-23.6	-\$162					
Нийт эдийн засгийн хэмжээнд	-4.1	-\$530	-6.0	-\$783		-4.1	-\$530	-6.0	-\$783

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Цар тахлын үед дэлхийн эдийн засгийн Монгол Улс дахь нөлөө гол төлөв хөдөө аж ахуй, уул уурхай, бизнес, худалдаа, хувийн болон нийтийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээний салбарт байгаа бол эдгээрийг сувагчлан авч үзвэл аялал жуулчлалаас бусад сувгаар дийлэнх нөлөөлөл нь илрэхээр байна.

1.4.2. Төсвийн бодлого

COVID 19-ийн улмаас хөл хорио тогтоож хил, гааль хаагдсантай холбогдуулан гадаад худалдааны эргэлт буурч, үүний дотор 2015 оноос 2019 он хүртэл тогтмол өсөлттэй буюу жилийн дундаж нийлмэл өсөлт нь 13 хувьтай байж 7.6 тэрбум ам.долларт хүрч байсан экспортын орлого энэ онд анх удаа буурсан бөгөөд 2020 оны эхний 9 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувиар буурч 5.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Ингэснээр энэ онд экспортын орлого 2018 оны түвшинд буюу 7.0 тэрбум ам.долларт хүрч чадах эсэх нь эргэлзээтэй байна.

ҮСХ-ноос 2020 оны 10-р сарын 13-ны өдөр гарсан нийгэм, эдийн засгийн байдлын статистикийн мэдээллээр 2020 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 13.5%-аар буурсан бол харин:

- Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 32.7%,
- Улсын нэгдсэн төсвийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 2.2 дахин,
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 3.6 дахин,
- Ажилгүйдлын даатгалын сангаас олгосон тэтгэмж 22.5%,
- 0-18 настай хүүхдийн мөнгөн тэтгэмж 4.3 дахин
- Өрхийн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь 1.4 пунктээр тус тус өссөн байна.

Ийнхүү цаг үеийн нөхцөл байдал, экспортын орлогын бууралт, урьдчилан төсөвлөөгүй зардлын өсөлт зэргээс үүдэн 2020 оны төсвийн тодотголоор төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 4.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 12.5 хувьтай тэнцэж байна.

1.4.3. Мөнгөний бодлого

2020.03.11-ний өдөр Монголбанк:

- бодлогын хүүг 100 bps буюу 1 хувиар бууруулж 10 хувь болгосон;
- банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 200 bps буюу 2 хувиар бууруулж 8.5 хувь болгосон;
- бодлогын хүүгийн коридорыг ± 1 хувь болгон нарийсгасан. Заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулснаар банкны системд 324 тэрбум төгрөг /ДНБ-ий 0.8 хувь/ –ийн эх үүсвэр чөлөөлөгдсөн гэсэн үг бөгөөд зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт, зээлийн хүртээмж, эдийн засгийн идэвхжүүлэхэд чиглэсэн бодлого юм.

2020.04.13-ны өдөр Монголбанк:

- бодлогын хүүг 1 хувиар бууруулж 9 хувь болгосон,
- хэрэглээний зээлтэй иргэдэд үндсэн зээл, хүүгийн төлбөрөө 12 сар хүртэл хугацаагаар хойшлуулах боломжийг олгосон байна.

2020.08.07-ны өдөр Монголбанк:

- эдийн засгийн хүндрэлтэй нөхцлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.
- Энэхүү шийдвэрийн хүрээнд нийт 76 мянга орчим зээлдэгчийн 663 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна.

2020.09.15-ны өдөр Монголбанкнаас бодлогын хүүг дахин 1 хувиар бууруулж 8 хувь болгосон.

1.4.4. Эдийн засгийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

COVID 19 цар тахлын эсрэг нийгэм, эдийн засагт учруулж буй хямралыг даван туулах, иргэд, ААН-ийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Засгийн газраас шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр дараах тэтгэмжүүдийг нэмэгдүүлсэн:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 80.0 мянган төгрөгөөр /Хэрэгжих хугацаа: 2020.04.01-12.31/;
- Нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр /Хэрэгжих хугацаа: 2020.05.01-12.31/;
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг 2 дахин /Хэрэгжих хугацаа: 2020.05.01-12.31/.

Засгийн газраас аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс дурьдвал:

- Үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагч, төрийн бус байгууллага, их, дээд сургуульд ажиллаж байгаа даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн төлөх ЭМДШ-с бусад шимтгэл буюу тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2020.04.01-2020.10.01-ний өдрийг хүртэл чөлөөлсөн ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцсон бөгөөд дээрх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах бусад орлогод ногдох хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөгдсөн. Ажил олгогч энэ хугацаанд албан татвар суутган төлөөгүй.
- 2020.10.01-2021.01.01-ний өдөр хүртэлх хугацаанд аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагч, сайн дурын даатгуулагч тус бүр 5.0 хувиар тооцож, нийгмийн даатгалын шимтгэл төлнө.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2019 оны тайлангаар 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой татвар төлөгч 2020.04.01-2020.10.01-ний өдрийг хүртэл хугацаанд олсон үйл ажиллагааны орлогод ногдох албан татвараас чөлөөлөгдсөн;
- Зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлэгч нь 2020.02.01-2020.09.01-ний өдрийг хүртэл хугацаанд бууруулсан түрээсийн төлбөрийн хэмжээгээр түрээсийн орлогод ногдох албан татварыг хөнгөлсөн;
- Коронавируст цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа төрийн бус өмчийн аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургуульд ажиллаж байгаа даатгуулагчид болон сайн дураар даатгуулагчдад 2020 оны 7 дугаар сараас сар бүр 200.0 мянган төгрөгийн дэмжлэгийг олгож эхэлсэн.

Нийгмийн халамжид 2020 оны эхний 9 сард давхардсан тоогоор 2.3 сая хүн хамрагдсаны дийлэнх нь буюу 1.2 сая нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байгаа 0-18 насны хүүхдүүд байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар, олгосон тэтгэмжийн хэмжээ 4.3 дахин нэмэгдсэн байна

Харин хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2020 оны эхний 9 сард 243.0 мянган хүн хамрагдаж, 39.3 тэрбум төгрөгийн үйлчилгээ авсан нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээнд хамрагдагсад 1506 /0.6%/ хүнээр буурч, үйлчилгээ 13.9 /54.8%/ тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.


2. АЗИ

2.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

COVID 19-ийн халдвар анх эхэлсэн бүс нутаг болох Ази тивд 2020.11.18-ны өдрийн байдлаар нийт 9,865,040 тохиолдол бүртгэгдсэнээс эдгэсэн тохиолдлын тоо 8,702,745 /88.22%/, нийт нас барсан тохиолдлын тоо 161,531 /1.64%/ байна. Шаардлагатай арга хэмжээнүүдийг тохиромжтой цаг хугацаанд авч хэрэгжүүлснээр Сингапур, Хятад зэрэг улсуудын шинэ тохиолдлын тоо харьцангуй бага болсон бол Энэтхэг, Бангладеш зэрэг оронд тахлын тархалт хурдтай үргэлжилсэн хэвээр байна.

Энэтхэг улсад бүртгэгдсэн тохиолдлын тоо 7,727,289 байгаа нь Ази тивд нийт бүртгэгдсэн тохиолдлын 78.3%-г эзэлж байгаа ба тус улсад нас барсан тохиолдлын тоо 117,011 байгаа нь Ази тив дэх нас барсан тохиолдлын 72.4%-г эзэлж байна. Энэтхэг улсад нас барагсдын тоо өндөр байгаа ч нийт халдвар авсан хүмүүсийн 1.51%-г эзэлж байгаа аж.

График 5. Голлох орнуудын халдвар бүртгэгдсэн тохиолдол



Эх сурвалж: <https://www.covid19.org/region/asia>

2.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ

БНХАУ:

2020.11.09-ний өдрийн байдлаар нийт 92,248 тохиолдол бүртгэгдсэнээс 4,748 хүн нас барж, 86,901 хүн эдгэжээ. Хамгийн их тохиолдол илэрсэн нь **Хубэй хот** /нийт 68,147 тохиолдол бүртгэгдэж 4,512 хүн нас барсан/ бол удаах хот нь Хонконг /нийт 5,380 тохиолдол бүртгэгдэж 107 хүн нас барсан/ байна.

Үүний дараагаар БНХАУ хурдавчилсан оношлуурыг хэрэглэж эхэлснээс гадна нэгдүгээр сарын эхээр богино хугацаанд олон тооны эмнэлэг барьж ашиглалтад оруулсан. Мөн орон нутгаас эмч нарыг дайчлан ажиллуулсан нь нөхцөл байдал хүндрэхээс сэргийлэхэд тусалсан байна. Түүнчлэн хязгаарлалт тогтоож, хөл хорьж, иргэдийг долоо хоногт нэгээс 2 удаа гарч хүнсээ авахаас өөрөөр гарахыг хориглосон нь халдварын тархалтыг бууруулахад үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Технологи талаасаа аппликейшн ашиглан хөл хориог хянаж байсан нь бас чухал арга хэмжээний нэг юм.

Сингапур:

2020.11.05-ны өдрийн байдлаар нийт 57,949 тохиолдол бүртгэгдсэнээс давтан илэрч тусгаарлалтад буй 26, эмнэлгийн хяналтад буй 40, нас барсан 28 тохиолдол бүртгэгджээ. /Тархалтын идэвхтэй үе 04-07 сар./ 1 сарын 23-нд Хятад улсаас тээвэрлэн авч ирсэн 66 настай Хятадын иргэнээс COVID 19-ийн анхны тохиолдол бүртгэгдсэн. Сингапур нь цар тахал тархаж эхэлмэгц өргөн хүрээнд COVID-19-н шинжилгээг тогтмол авч, хавьтаж ойртсон хүмүүсийн мэдээллийг хянан, сайтар тусгаарлах замаар вирус халдварыг удирдаж байсан. Гэхдээ гадаад ажилчдын дотуур байртай холбоотойгоор тус улсад COVID 19-ийн халдвар тархсан байна. Гэсэн хэдий ч сүүлийн 6 сарын турш анх удаа буюу 10 сарын 13-наас хойш дотооддоо халдвар авсан хүмүүсийн шинэ тохиолдолд бүртгэгдээгүй байна.

Энэтхэг улс:

Анхны тохиолдол 1.30-нд Ухань хотоос Керала-д буцаж ирсэн оюутнаас илэрсэн. Ерөнхий сайд Модди 3.24-нд улс орон даяар хөл хорио тогтоосон.

6 сараас цар тахлын тоо эрчимтэй нэмэгдсэн. Хүн амын амжиргааны түвшин зөрүүтэй буюу баян ядуугийн ялгаа их, мөн эмнэлгийн хүрэлцээ хангалтгүйгээс гэрт нь эмчлэх бодлого барьсантай холбоотой ийнхүү дэлгэрсэн байх магадлал өндөр гэж судлаачид үзэж байна.

7-р сарын 29-нд төв засгийн газар 'Unlock 3.0' удирдамж гаргаж, улс орон даяар үйл ажиллагааг үе шаттайгаар дахин нээх, зөвхөн хязгаарлалтын бүсэд хөл хориог 8-р сарын 31 хүртэл сунгасан байна. 8-р сарын 29-нд засгийн газар дараагийн буюу 'Unlock 4.0' хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

- 9-р сард эдийн засгаа цаашид нээж, 9-р сарын 7-ны өдрөөс эхлэн метроны төмөр замын хязгаарлалтыг үе шаттайгаар арилгах
- 100 хүртэлх хүний нийгэм, эрдэм шинжилгээний, спорт, зугаа цэнгэл болон бусад хурлуудад оролцохыг нээлттэй болгох

9-р сарын 30-нд төв засгийн газар "Unlock 5.0" удирдамж гаргаж муж улс /нэгдлийн нутаг дэвсгэрийн 10-р сарын 15-наас хойш сургуулийн үйл ажиллагааг нээсэн. 10-р сарын 15-наас эхлэн цэнгээний газрууд нээгдэхийг зөвшөөрч, цугларч болох хүний тоог 200 хүн болгон нэмэгдүүлсэн байна.

2.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ

2.3.1. Хууль, эрх зүй:

Сингапур:

COVID-19 /temporary measures/ эрх зүйн акт 2020 боловсруулсан. Анх боловсруулсан огноо нь 2020.04.07, нэмэлт өөрчлөлт оруулсан нь 2020.06.05 ба 2020.09.18. Уг актад дараах хүрэнүүд хамарч байна. Үүнд:

- Гэрээний үүргээ биелүүлэх чадамжгүй тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх
- ЖДҮ болон ТББ-д түрээсийн хөнгөлөлт үзүүлэх
- Санхүүгийн хямралд өртсөн хувь хүн, бизнест хөнгөлөлт үзүүлэх
- Барилгажилт хойшилсонтой холбоотой гэрээний хөнгөлөлт

- Багцын борлуулалт концессын арга хэмжээ
- COVID-19 вируст ноцтой өртсөн бизнесийн дахин хэлэлцээрийн тухай тус тус багтжээ.

Эх сурвалж: Сингапурын хууль зүйн яамны цахим хуудас

Энэтхэг улс:

2020.04.15-д Энэтхэгийн дотоод хэргийн яамнаас “COVID-19 цар тахалтай холбоотой нэдсэн удирдамж”-ийг боловсруулсан. /Эх сурвалж: Энэтхэгийн дотоод хэргийн яам/

2.3.2. Сонгууль:

Сингапур:

2020 оны 07 сарын 10-нд улсын их хурлын сонгуулийг хэвийн зохион байгуулсан.

Энэтхэг улс

2020 онд нийт 3 сонгууль зохион байгуулахаар байсан ч бүгд хойшилсон.


- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль: 05 сард сонгуулийг хойшлуулж, 10 сарын 20-ны өдөр рүү шилжүүлсэн. Гэсэн хэдий ч сонгууль 3 үе шаттайгаар буюу 10 сарын 28, 11 сарын 03 болон 11 сарын 07-нд сонгууль явагдсан.
- Улсын их хурлын сонгууль: 05 сард сонгуулийг хойшлуулж, 10 сарын 20-ны өдөр рүү шилжүүлсэн. Гэсэн хэдий ч сонгууль 3 үе шаттайгаар буюу 10 сарын 28, 11 сарын 03 болон 11 сарын 07-нд сонгууль явагдсан.
- Хууль тогтоох чуулганы сонгууль: Дели хотод 2020.02.08-нд саналыг авсан ба Бихарт болох сонгуулийг 03 сарын 24-ний өдөр сонгуулийг хойшлуулж, 06 сарын 19-ний өдөр рүү шилжүүлсэн ч сонгууль ахин хойшлон, 3 үе шаттайгаар буюу 10-11 сард болсон байна.

2.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ

БНХАУ:

ДНБ-ний өсөлт:

График 6. БНХАУ ДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Statista.com


2020 оны 01 сарын эхээр Хятад улсын Ухань хотод анх COVID 19-ийн халдвар илэрсэн. Үүнээс үүдэн Хятад улс нь үндэсний сар шинийн баяр болон бусад баяр ёслолуудыг тэмдэглэхийг хорьж, хилээ хаан, үндэсний түвшинд хөл хорио тогтоосон. Коронавирусээс улбаалж Хятадын эдийн засаг 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.8%-иар агшсан байна. Гэсэн хэдий ч ажилгүйдлийн хувьд өөрчлөлт ороогүй байна.

2 сарын дунд үеэс эхлэн хязгаарлалтыг сулруулсан бөгөөд чухал сектор, аж үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээж эхэлжээ. Ихэнх ААН, сургуулиуд үндэсний хэмжээнд эргэн нээгдсэн ч social distancing буюу зай барих бодлого микро түвшинд үйлчилж, гаднаас нэвтрэх хориг хэвээр үлдсэн байна. Орон нутгийн хөдөлгөөний хязгаарлалтыг зүүн хойд Гилинь, Хэйлунцзян, Шинжаан мужууд, Бээжин, Далянь, саяхан Чиндао зэрэг халуун цэгүүдэд дахин ногдуулж, орон нутаг дахь цар тахлын дэгдэлт хяналтад орсны дараа эдгээр хязгаарлалтыг бүгдийг нь цуцалжээ. Ийнхүү эдийн засгийн үйл ажиллагааг боломжит хэвийн түвшинд аваачсаны дараа буюу 2-р улиралд бодит ДНБ 3.2%-р, 3-р улирлын байдлаар бодит ДНБ 4.9%-р өссөн /уоу/ байна. Энэ жил дэлхийн хөгжингүй болон шинээр сэргэж буй томоохон эдийн засгууд бүгд хасахтай гарч байгаа бөгөөд ганцхан улсын эдийн засаг нэмэх өсөлттэй байгаа нь Хятад аж. Хятадын эдийн засаг 2020 онд 1 хувиар өсөх төлөвтэй гэж Олон улсын валютын сан 6 дугаар сард гаргасан тайландаа дурджээ

Сингапур:

ДНБ-ий өсөлт:

График 7. Сингапур ДНБ-ний өсөлт




Эх сурвалж: Statista.com

Сингапур улсын ДНБ-ний өөрчлөлт сүүлийн 2 жилд харьцангуй тогтвортой байсан ч 2020 оны II улиралд -13.2%-г хүрч үүнээс 7.9% нь 2020 оны III улиралд эргэн өссөн байна. Байр болон хоолны үйлчилгээний салбар тахлын нөлөөлөлд хамгийн ихээр өртсөн бол тээвэр болон агуулахын салбар, урлагийн салбар, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь нөлөлөл мөн чамлахааргүй өндөр байна.

Энэтхэг улс:

COVID-19-ийн нөлөөллөөс үүдэн 2020 оны 02-р улиралд ДНБ нь өмнөх оны мөн үеэс 23.9%-р агшсан байна. 04.15-наас эдийн засгийн салбараа дэмжихийн тулд газар зүйн бүсчлэлээр бизнесүүдийг ялгаатайгаар сэргээж, 05.25-с дотоодын агаарын нислэгийг хэвийн явуулж эхэлжээ.

График 8. Энэтхэг улсын ДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Statista.com

2.4.1. Төсвийн бодлого:

БНХАУ:

ДНБ-ийн 4.5%-тай тэнцэх дүн болох ойролцоогоор 4.6 их наяд юаньтай тэнцэх дүнгээр дискрет сангийн бодлогыг хэрэгжүүлэхээ зарласан. Мөн эрүүл мэндийн секторт нэмэлтээр 147 тэрбум юань зарцуулсан байна.

- **ЖДҮ, байгууллагын хэвийн үйл ажиллагааг дэмжих, ажилчдыг дэмжихэд чиглэсэн зарцуулалт [3.1 их наяд юань].** Үүнд:
 - Цахилгаан болон байгалийн хийн үнийг бууруулсан. Улмаар аж ахуйн нэгжүүд 2 тэрбум юанийг хэмнэх боломжтой болсон байна. Уг шийдвэрийн дагуу 2020.02.01-с 2020.06.30-ны өдрийг хүртэл Шанхайн аж ахуйн нэгжүүд /эрчим хүч ихээр хэрэглэдэг аж ахуйн нэгжүүдээс бусад/-ийн цахилгааны үнийг 5 хувиар бууруулах бөгөөд үүнд нийт 750 мянга гаруй аж ахуйн нэгж хамрагдаж байна.
 - Бээжин хотын харьяа дүүргийн улсын үйлдвэрийн газрын байранд ажил үйлдвэрлэл эрхэлдэг жижиг, дунд үйлдвэрийг Засгийн газрын шаардлагаар ажил үйлчилгээ эрхлүүлэх эсхүл, үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд 2 дугаар сарын байрны түрээсийн төлбөрөөс чөлөөлөх, оффисын зориулалтаар түрээсэлдэг бол мөн сарын түрээсийн зардлыг 50 хувиар бууруулсан байна.
- **Татвар, НДШ-с чөлөөлөх [ДНБ-ийн 4.5% буюу 1.5 их наяд юань].** Үүнд:
 - Сангийн яам орон нутгийн засаг захиргаанд 2020 оны 3-р сараас 6-р сар хүртэл 5% -иар илүү татварын орлогоо хадгалах боломжийг олгох /орон нутгийн нийт орлогыг 110 тэрбум юаниар өсгөсөн /
 - Өвчний гамшигт нэрвэгдсэн тээвэр үйлчилгээ, аялал жуулчлал, нийтийн хоол, түрээсийн байр, хүргэлтийн үйлчилгээ, иргэний агаарын салбарын үйл ажиллагааг НӨАТ-аас чөлөөлөх.
 - Хубэй мужид хүнсний ногооны үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөл, аж ахуйн нэгжийг НӨАТ, ХХОАТ болон бусад татвараас бүрэн чөлөөлөх.

- Халдварын аюулаас сэргийлэх, хамгаалах материал үйлдвэрлэгч аж ахуй нэгжид НӨАТ-ыг сар бүр буцаан олгох. Халдварт өвчнөөс сэргийлэх, хамгаалах бараа материал тээвэрлэсэн иргэнийг орлогын болон НӨАТ-с чөлөөлөх.
- Хубэй мужийн бичил бизнес эрхлэгч буюу өрхийн бизнес эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийн НӨАТ хувь хэмжээг бууруулах. Бусад муж, хотуудын энэ төрлийн бизнес эрхлэгчдийн НӨАТ-ын хувь хэмжээг буулгаж 1% болгов. 2020.12.31 хүртэл хүчинтэй.
- 2 дугаар сараас эхлэн жижиг дунд аж ахуй нэгжийг нийгмийн даатгалын төлбөрөөс 5 сар хүртэлх хугацаагаар чөлөөлөх бөгөөд томоохон аж ахуй нэгжийг нийгмийн даатгалаас 3 хүртэлх сарын хугацаагаар тус тус чөлөөлнө. Хубэй мужид нийгмийн даатгалын төлбөрийг төрийн байгууллагаас бусад бүх аж ахуй нэгжид 5 хүртэлх сарын хугацаагаар чөлөөлөх.
- Коронавирусний халдварт нэрвэгдсэн үйлдвэрлэл, ахуй нэгж нийгмийн даатгалын төлбөрийг 6 хүртэлх сараар хойшлуулж болох бөгөөд хойшлуулсан хугацаанд төлбөрийг төлөхгүй байж болно
- 2-р сараас эхлэн аж ахуй нэгжүүд 5 хүртэлх сарын хугацаанд ажилчдын эрүүл мэндийн даатгалыг 50%-иар тооцон төлж болно.
- **Цар тахлын тархалтаас сэргийлэх болон хяналтыг сайжруулахад чиглэсэн зарцуулалт [147 тэрбум юань]**
- Зарлагыг дэмжих зорилгоорх орон нутгийн бонд гаргалт [1.6 их наяд юань]

Эх сурвалж: ОУВС, KPMG, Montsame, Хятадын сангийн яам

Сингапур:

Эрх баригчид төсвийн дэмжлэг үзүүлэх хэд хэдэн багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба тэдгээр нь нийт 100 орчим тэрбум сингапур долларын өртөгтэй байна. Энэхүү дэмжлэгт:

- **Сингапурын өрхүүдэд олгох мөнгөн дэмжлэг /5.9 тэрбум сингапур доллар/** – Гэр бүлийн 1 гишүүн дунджаар 1050 сингапур доллар. Нэмэлтээр 10 сарын 15-аас 300,000 гаруй өрх айлд ваучер схемийн дагуу хөнгөлөлт /тус бүр 50 доллар/ үзүүлэхээ мэдэгдсэн.
- **Бага орлоготой иргэд, ажилгүйчүүдэд олгох нэмэлт дэмжлэг /69 тэрбум сингапур доллар/-** 3 схем бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.
 - Temporary Relief Fund: Зөвхөн 4 сард хэрэгжсэн. Цар тахлаас үүдэн ажилгүй болсон, эсвэл орлогын дийлэнх хэсгийг алдсан буюу дараах шаардлагыг хангасан иргэд 1 удаа эргэн төлөх нөхцөлгүй 500 долларын дэмжлэг авна.
 - COVID-19 Support Grant: Дараах шаардлагыг хангасан иргэд онлайнгаар хүсэлтээ бөглөн, 3 сарын хугацаанд 800 доллар хүртэлх буцалтгүй тусламж авна. Хүсэлтийг 05 сарын 04-с хүлээн авч эхэлсэн ба хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа 2020.12.31.
 - The Courage Fund: Дараах шаардлагыг хангасан иргэд онлайнгаар хүсэлтээ бөглөн, нэг удаад 1000 доллар хүртэлх буцалтгүй тусламж авна. Хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа байхгүй.
- **Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг** нь цалингийн татаас /2021 оны 3-р сар хүртэл, салбараас хамаарч дэмжлэгийн түвшинтэй/, компани, хувиараа бизнес эрхлэгчид болон ажиллагсдын орлогын албан татварыг 2020 оны 04-06 сарын хугацаанд 3 сар хойшлуулсан байна.

- **Түрээсийн зардлыг нөхөх дэмжлэг** нь түрээслэгч рүү чиглэсэн. Орлого буурсан түрээслэгчдийн хувьд засгийн газар болон түрээслүүлэгчээс үзүүлэх хөнгөлөлт нь 4 сарын хугацааг хамарч байна.

Засгийн газрын зүгээс: Жилийн эргэц нь 100 сая сингапур доллараас бага орлоготой бол 2020 оны 4 болон 5 сард

- Үйлчилгээний талбай түрээслэгчдийн сар бүрийн зардлын 0.8 сарын түрээсийн зардлыг /2 сарын турш/
- Аж үйлдвэрийн болон оффисын талбай түрээслэгчдийн 0.64 сарын түрээсийн зардлыг /1 сарын турш/
- ОУВС-с Сингапурын ДНБ-н өсөлтийг эхэндээ -7% байна гэж таамаглаж байсан ч уг таамаглалаа өсгөж -4% байхаар таамаглаад байна.
- 2020 оны төсвийн төсөөлөлд 2 удаа тодотгол хийсэн.
- 2019 оны төсвийн орлогын 38.7%-г ААНОАТ болон ХХОАТ эзэлж байна. COVID-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн эдгээр орлого буурсан ба 2020 оны төсвийн орлого таамагласан дүнгээс 5.1 тэрбум ам.доллараар бага, өмнөх онтой харьцуулахад 14.7%-р буурахаар хүлээгдэж байна.
- Төсвийн зардал ихэсч, өнгөрсөн жилээс 30.6%-р өсөхөөр хүлээгдэж байна.

Эх сурвалж: data.gov.sg, Сингапурын сангийн яамны цахим хуудас

Энэтхэг улс:

- Шууд зарцуулалт /direct spending/ [ДНБ-ий 2 орчим хувь]
- Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор боловсруулсан below-the-line буюу зээллэгийг дэмжих арга хэмжээ [ДНБ-ий 5.2 хувь]

Гол арга хэмжээнүүд нь:

- Бага орлоготой өрхүүдэд хоол, газ гэх мэт мөнгөн бус халамж ба мөнгөн шилжүүлэг [ДНБ-ий 1.9%]
- Цахилгаан эрчим хүчний түгээлтийн компаниудад зориулсан дэмжлэг [ДНБ-ий 0.4%]
- Хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх дэмжлэг [ДНБ-ий 0.4%]
- Эрүүл мэндийн салбарын дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн зарцуулалт [ДНБ-ий 0.1%]. Үүнд
- Татварын хойшлуулалт, хөнгөлөлт [ДНБ-ий 0.4%]

Зэрэгт зарцуулсан байна. 10 сард эрх баригчид нэмж ДНБ-ий 0.2%-тай тэнцэх дүнг төсвийн хөрөнгө оруулалт, зарцуулалтыг дэмжихэд зарцуулахаа мэдэгдсэн.

- 2018-2019 оны санхүүгийн жилийн татвар төлөлтийг 06.30-ны дотор төлж барагдуулахаар хойшлуулсан ба энэ хугацаанд торгуулийн хүү бодоогүй.

2.4.2. Мөнгөний бодлого:

БНХАУ:

Хятад улсын төв банк болох РВС санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд дараах бодлого баримталсан. Үүнд:

- Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа /урвуу репо болон дунд хугацаат зээлийн санхүүжилт/-гаар дамжуулан банкны систем дэх хөрвөх чадварыг нэмэгдүүлэх. Үүнд: 7 хоног болон 14

хоногийн хугацаатай урвуу репо хэлцлийн хүүг 30bps- р бууруулах, түүнчлэн 1 жилийн буюу дунд хугацааны зээллэгийн хүүг 30bps-р бууруулах

- Зорилтот заавал байлгах нөөцийн хүүг 50-100bps р бууруулах. /Ингэснээр зах зээлд 550 тэрбум юанийг эргэлтэд оруулсан/
- Хувийн байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох зээлийн шугамын дүнг 350 тэрбум юань хүртэл нэмэгдүүлэх
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжихийн тулд дотоодын банкуудад 0 хувийн хүүтэй 400 тэрбум юанийн санхүүжилт олгон, барьцаагүйгээр зээл олгохыг хөшүүрэгдэх
- Эмнэлгийн хэрэгсэл, өдөр тутмын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчид, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор 1.8 их наяд юаниар дахин зээл олгох, хөнгөлөлт үзүүлэх. Үүнд: Зээл дахин олгох/санхүүжүүлэхэд сарын хүүг 50bps -р бууруулах, нөхцөлд өөрчлөлт оруулахад хүүг мөн 25 bps -аар бууруулах,

Эргэн төлөлтийн хүндрэлтэй нүүр тулж буй өрхүүд, корпорациудын хувьд санхүүгийн дарамтыг бууруулахад чиглэсэн дараах арга хэмжээг мөн авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээллэгийг дэмжих үүднээс барьцаагүй SME зээл олголтын хувийг 40% хүртэл нэмэгдүүлэх
- Зээлийн эргэн төлөлтийг 2021.03 сар хүртэл хойшлуулах
- Актив ангилах журам, бодлогоо зөөлрүүлэх
- Санхүүгийн байгууллагуудын бонд гаргалтыг дэмжих
- Жагсаалтад орсон аж ахуйн нэгжид /эм, эмнэлгийн багаж, хэрэгсэл үйлдвэрлэгч аж ахуй нэгж, эмнэлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдах түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч компани, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, хамгаалах, тээвэрлэгч аж ахуй нэгжүүд хамаарна/ санхүүгийн дэмжлэг үзүүлэх буюу хөнгөлөлттэй зээл олгох ба зээлийн хүүгийн 50%-ийг төр засгаас хөнгөлөх бөгөөд хөнгөлөлттэй зээлийн хугацаа 1 жил байна.

Сингапур:

Гуравдугаар сарын 31-нд Сингапурын Мөнгөний Бодлогын Хороо нь банк, санхүүгийн салбар дахь COVID-19-н нөлөөллөөс үүдэн бэлэн мөнгөний урсгалын түр зуурын бэрхшээлтэй тулгарсан иргэд, ЖДҮ эрхлэгчдэд туслах арга хэмжээний дэлгэрэнгүй багцыг зарлав. Багц нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй:

- Иргэдэд зээл, даатгалын үүргээ биелүүлэхэд нь туслах;
- ЖДҮ-ийг банкны зээлд хамрагдах боломжийг үргэлжлүүлэн дэмжих;
- Банк хоорондын санхүүжилтийн зах зээл хөрвөх чадвар сайтай, сайн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Сингапурын банкуудад долоо хоног бүрийн даваа гаригт болдог дуудлага худалдаагаар дамжуулан ам.долларын хөрвөх чадварыг хангах зорилгоор 3-р сарын 19-нд Сингапурын МБХ нь АНУ-ын Холбооны нөөцийн газартай 60 тэрбум долларын своп хэлцэл байгуулсан. Хэлцлийн дуусах хугацаа 2021.3 сар.

Овернайт хүүг мөн үе шаттайгаар бууруулсан ба 2020.2 сард хүү 1.6% байсан бол өнөөдрийн байдлаар 0.8%-тай тэнцэж байна.

2020 оны 4-р сарын 8-ны өдөр МБХ-с санхүүгийн үйлчилгээ болон FinTech-ийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор 125 сая долларын дэмжлэг үзүүлэх багцыг зарласан. Санхүүгийн салбарыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлж буй багц нь гурван үндсэн тулгууртай байна:

- Ажиллах хүчний сургалт, ажиллах хүчний зардлыг дэмжих;
- Дижиталжуулалт, үйл ажиллагааны уян хатан чанарыг бэхжүүлэх;
- FinTech пүүсүүдийн дижитал хэрэгсэлд нэвтрэх боломжийг сайжруулах.

09 сарын 03-нд МБХ-с банкны системийн гадаад валютын хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор овернайт зээлийн хугацааг 1 сар, 3 сар болгосон байна.

10-р сарын 5-ны өдөр МБХ зээлийн эргэн төлөлтийг үргэлжлүүлэхэд илүү их цаг хугацаа шаардагдах иргэд, ЖДҮ эрхлэгчдэд өргөтгөсөн дэмжлэг үзүүлэхээ мэдэгдэв. Орон сууц, ҮХХ-ийн болон аж үйлдвэрийн зориулалттай /бизнесийн/ зээлтэй, зээлийн эргэн төлөлтөө үргэлжлүүлж чадахгүй байгаа иргэд зээлийн төлбөрөө сарын төлбөрийн 60 хувьтай тэнцүү хэмжээгээр бууруулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд шаардлага хангасан ЖДҮ эрхлэгчид баталгаат зээлийн үндсэн төлбөрийн 80 хувийг хойшлуулахаар шийдэж болох аж.

Шалгуур нь: Өмнө нь төлбөрөөс чөлөөлөгдсөн эсэхээс үл хамааран орлого нь COVID-19-н нөлөөллөөс үүдэн дор хаяж 25%-р буурсан, 90-с дээш хоног хугацаа хэтрээгүй зээлдэгч нар 2020.11.09-с 2021.06.30 хүртэл хүсэлт гаргаж болно.

Сургалтын зээлтэй хувь хүмүүс зээлийн нийт хугацааг 3 жил хүртэл сунгаж болох шийдвэр мөн гарчээ.

Энэтхэг улс:

2020.03 сараас Энэтхэгийн төв банк

- Репо болон урвуу репо хэлцлийн хүүг харгалзан 115 болон 155 bps-р бууруулан 4.0 болон 3.5% болгосон
- Урт хугацаат репо хэлцэл, бэлэн мөнгөний нөөцийн харьцааг 100 bps-р бууруулан 80% болгосон
- Хөрвөх чадварын харьцааг 3% болгосон ба эдгээр нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг энэ хэвээр нь 2021.03 сар хүртэл үргэлжлүүлэхийг мэдэгдсэн.

Мөнгөний зөөлөн бодлого баримталж буйн хүрээнд 4 сарын 17-20 ны хооронд төв банкнаас дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг зарласан:

- Зорилтот урт хугацаат дахин санхүүжилтийн хөтөлбөр 2.0 /TLTRO-2.0/: Нэмэлт 50 их наяд рупи- г банк бус санхүүгийн байгууллагуудад бондыг нь худалдан авах замаар олгосон. 3 жилийн хугацаатай. Бондод тавигдах шаардлага нь BBB-с дээш зэрэглэлийн буюу хөрөнгө оруулалтын бонд байх. /Banks cannot use the version 2.0 money to lend to corporates-only NBFCs/.
- Орон нутгийн банкууд, орон сууцны санхүүгийн компаниуд, жижиг, дунд үйлдвэрүүдэд зориулагдсан дахин санхүүжүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлсэн.
- Актив ангилах журамд өөрчлөлт оруулсан, 90-с дотогш хоногийн төлбөрийн зөрчилтэй зээлүүдийн хувьд нөхцөлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

5 сарын 13-нд ЗГ зорилтот бизнесүүдэд зориулан дараах мэдэгдлийг мөн гаргав. Үүнд:

- 100%-н баталгаатайгаар барьцаагүй зээл олгох [3 их наяд рупи]
- Өрийн дарамтад орж буй бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хэсэгчилсэн баталгаа [5.5 их наяд рупи]

8 сарын 06-нд төв банкнаас 03 сарын 01-с хойш ангилагдсан үлдэгдэлтэй зээлүүдийн бүтцэд өөрчлөлт оруулж, ангиллыг “хэвийн” болгох тухай мэдэгдэл хийсэн байна. 9-р сарын 22-нд УИХ-аас Энэтхэгийн Дампуурлын тухай баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 2021 оны 3-р сарын 25-ны өдрийг хүртэл төлбөрийн чадваргүй болох тохиолдол гарахгүй гэжээ.

2.4.3. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн бодлого

БНХАУ:

Технологийн шийдэл: Ухаалаг гар утасны апп зохион бүтээсэн ба үүгээрээ хүмүүсийг эрүүл мэндийн байдал болон зорчсон газруудын мэдээллийг бүртгэж байна. Энэ аппликейшний онцлог нь Bluetooth ашиглан эргэн тойронд байгаа хүмүүсийг харилцан бүртгэх ба улмаар тэрхүү хүмүүсээс хэн нэг нь өвчилмөгц танд мэдээлэл ирнэ. /Мөн эрүүл мэндийн байгууллага хавьтлыг илрүүлэх боломжтой болж буй юм./ Түүнчлэн, гудамжны камеруудыг өвчнийг хянахад ашиглаж байна. Маск зүүгээгүй хүн, өвчний шинж тэмдэг илэрч буй хүнийг царай таних кодчлолын тусламжтайгаар илрүүлж буй аж.

Хөл хорио тогтоолт: 1 сарын 22-ны байдлаар дэлхий дахинаа нийт 581 тохиолдол бүртгэгдсэний 571 нь Хятад улсад, үүнээс 375 нь Хубэй мужид бүртгэгдсэн байна. Иймээс 1 сарын 24-нээс Хубэй муж дахь агаарын болоод газрын тээврийн хэрэгслийн гадагш гарах, дотогш нэвтрэх үйл ажиллагааг бүрэн зогсоож, хөл хорио тогтоожээ. Хөл хориотой холбогдуулан хүнсний дэлгүүр болон эмийн сангаас бусад дэлгүүрүүдийн үйл ажиллагаа зогссон байна. Нийт 13 хотод хатуу хөл хорио тогтоосон. Олон нийтийн арга хэмжээ зохиохыг хориглон, сурагчдын амралтыг сунган, хилээ хаав. Хөл хорио 3 сар дуустал үргэлжилсэн. 6 сард Бээжин хотод тахлын тоо эрчимтэй нэмэгдэж байсан учир хэсэгчлэн хөл хорио тогтоон, хагас сая хүн хөл хорионд орсон байна. Хятад улсын ЗГ-с хөл хорио тогтоосон хэсэг дэх хүмүүст түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийн, улмаар тархалтыг илүү хурдацтай тархахаас сэргийлж ажиллаж чаджээ.

Эмнэлэг: Өдрөөс өдөрт нэмэгдэж буй цар тахлын тохиолдлоос үүдэн Ухань хотод 1000 ортой эмнэлэг, 1500 ортой эмнэлэг тус бүрийг 10 хоногийн дотор барьж, ашиглалтад оруулав. Эхэн үед 40,000 гаруй эмнэлгийн салбарын ажилтнууд Ухань хот руу явж, өвчинтэй тэмцсэн байна. /Нас барагсдын ихэнх нь өндөр настай хүмүүс байсан учир тэдгээрийг тусгай эмнэлэгт хэвтэн эмчилж байжээ./ Ерөнхийдөө засгийн газрын зүгээс Өвчтөнүүд, Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, Нөөц болон Эмчилгээнд анхаарах буюу “Four Concentrations” гэх зарчмыг баримталж байгаа аж. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өдөрт мянга мянгаар нэмэгдэж байсан тохиолдлын тоо 100, 10-р хэмжигдэхүйц болж буурсан байна. Итали, Испани гэх мэт Европын улсуудад тохиолдлын тоо огцом нэмэгдэж байсан үед Хятад улс нь өөрийн эмнэлгийн тусгай хүчнийг тэдгээр улс руу мөн илгээжээ.

Хятад улсын тусламж:

- 4 сарын 21-нд Жакарта хотод байрлах Зүүн өмнөд Азийн холбоонд 75,000 эмнэлгийн мэс заслын маск, 300 сав бүхий гар ариутгагч, 35 халуун хэмжигч хандивласан.
- Малайз улсад 03 сарын 19, 03 сарын 28-д эмнэлгийн хэрэгслүүдийг хандивласан.

- Филиппин улсад эмнэлгийн хандив 8 удаа өгсөн.
- Тайланд улсад 9 сая доллартай тэнцэх хэмжээний эмнэлгийн багаж хэрэгслүүд илгээсэн.
- Индонез, Лаос, Камбож Мянмар зэрэг бусад 120 гаруй улсад Хятадын засгийн газрын дэмжлэг үзүүлсэн ба засгийн газрын дэмжлэгээс гадна Алибаба, Жак ма зэрэг сангуудын зүгээс мөн буцалтгүй тусламж, хандив үзүүлсэн байна.
- Монгол улсын ерөнхийлөгч 02 сарын 27-д Хятад улсад айлчлахдаа 30,000 хонь бэлэглэсэн ба монголын ард түмэн хандив цуглуулан, ойролцоогоор 5 сая юанийг Хятад улсад хандивлажээ.

Сингапур:

Сингапурын эрүүл мэднийн яамны мэдээлснээр халдвар авсан иргэдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхэд орны нөөц харьцангуй боломжтой байжээ. Сингапурын хувьд, халдвар авч эмчлэгдсэн ч шинжилгээний хариу эерэг гарч байгаа өвчтөнүүдийг тусгай эмнэлгүүдэд ахин хуваарилж, хяналтад байлгадаг ба сөрөг гарч эдгэсэн өвчтөнүүдийг 14 хоног тусгаарлаж байна.

- 1 сарын 23-нд Хятад улсаас тээвэрлэн авч ирсэн 66 настай Хятадын иргэнээс COVID 19-ийн анхны тохиолдол бүртгэгдсэн учир Сингапур нь 1 сарын 31-с Хятад улсаас жуулчин хүлээж авахыг түр хязгаарласан.
- 3-р сарын 22-нд хот мужийн зүгээс богино хугацааны бүх жуулчдыг Сингапур руу нэвтрэхийг хоригложээ. /Сингапурт ажиллах зөвшөөрөлтэй малайзчуудад тус улсад үргэлжлүүлэн ажиллахыг зөвшөөрөв. Бусад харьяалалгүй хүмүүсээс зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг зайлшгүй шаардлагатай салбарт ажиллах зөвшөөрөл эзэмшигчид нэвтрэхийг зөвшөөрсөн./
- COVID-19 өвчнөөр нас барсан 2 хүний дараа буюу 3 сарын 21-с эхлэн Сингапурын хувьд COVID-19 н 2-р үе эхэлсэн гэж үзэж байна. Энэ үед гаргасан нэг гол шийдвэр нь сургуулийн үйл ажиллагааг ахин нээх нь зүйтэй гэсэн шийдвэр байв. Хэдийгээр өвчлөлийн тоо нэмэгдэж байсан ч насанд хүрэгчид хүүхдүүдээс илүү өвдөх хандлагатай байна гэж үзэн ийнхүү нээсэн байна. Харин дараа нь сүм хийд, хурал уулзалт зохион байгуулдаг зочид буудлууд болон цэцэрлэгийн өмнөх боловсролын байгууллагуудаар дамжин COVID-19-н тохиолдлын тоо нэмэгдсээр байжээ. Өмнө нь гаргасан шийдвэр бодлого гаргагчдыг төөрөгдөлд оруулав. Засгийн газар хариу арга хэмжээ авч, хил хязгаарыг хааж, олон нийтийн арга хэмжээ, олон нийтийн цугларалтыг хориглож, бүх сургуулиудыг түр хугацаанд хааж, HomeBased Learning форматаар хичээлээ онлайнаар зааж эхэлсэн аж.
- 4-р сарын 5-нд Сингапур 20,000 гадаад/цагаач ажилчдын байрлаж буй дотуур байранд хорио цээр тогтоосон бөгөөд дийлэнх нь Өмнөд Азиас гаралтай, хүнд нөхцөлд амьдардаг хөх захтанууд /хар бор ажиллагсад/ байдаг аж. Эрүүл мэнд, ажиллах хүчний яамдын удирдсан ажлын хэсэг хорио цээр тогтоосон гадаад ажилчдад хангамж, хоол хүнс, эмнэлгийн тусламж хүргэх зорилгоор тусгай баг ажиллуулав.
- 4 сарын 21-нд ард түмнийг 06.01 хүртэл тусгаарлалтын горимд байх буюу заавал гэртээ байхыг мэдэгдсэн. 06 сарын 02-нд сургуулийг бага багаар буцаан нээсэн ба гурван хүн тутмын 1-ийг оффис болон үйлдвэртээ ирж ажиллахыг зөвшөөрсөн байна. 06 сарын 19-нээс 5 хүртэлх хүнээс бүрдэх бага хэмжээний цугларалт, рестораны үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн. 06 сарын 29 нд бага, дунд болон коллежийн оюутнууд сургуульдаа өдөр тутам явах боломжтой болов.

- 06 сарын 26-с хамгийн ихдээ 50 хүн цугларахыг зөвшөөрөв.
- 07 сарын 17-нд үндэсний хөгжлийн яамны сайд Лаурэнс дотуур байранд амьдардаг гадаад ажилтнуудыг бүгдийг нь шинжилгээнд хамруулах ажиллагааг эхлүүлсэн ба ойролцоогоор 1 сарын дотор бүрэн шинжилнэ гэж тооцоолсон байна.
- 07 сарын 01-с үйл ажиллагааны хүчин чадлынхаа 25%-д гадны жуулчдыг хүлээн авч эхэлсэн.
- Иргэддээ цар тахалтай холбоотой тогтмол мэдээллийг Whatsapp апп-р дамжуулан өдөр бүр хүргэж байгаа ба тусгаарлалтад буй хүмүүсийг хянадаг хиймэл оюун ухаанд суурилсан апп-г мөн шинээр бүтээсэн байна.

Эх сурвалж: Олон улсын стратеги, судалгааны төв

Гадаад иргэдийн хувьд:

- Сингапурт оршин суух эрхтэй гадаад улсын иргэн 14 хоногийн тусгаарлах заалтыг зөрчсөн тохиолдолд оршин суух эрхийг нь /байнгын оршин суугчийн үнэмлэх, оюутны виз, ажил эрхлэх виз, хөрөнгө оруулагчийн виз зэрэг бүх төрөл хамаарна/ цуцалж, 24 цагийн дотор нутаг буцаах арга хэмжээг авна.
- Сингапурт байгаа гадаад улсын иргэд шинэ төрлийн коронавируст халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдолд зайлшгүй эмчилгээнд хамрагдахын сацуу эмчилгээний зардлыг өөрөө хариуцна. Сингапурын засгийн газраас зөвхөн оношилгооны зардлыг чөлөөлнө.
- Эмнэлгийн үйлчилгээний нөөц боломж хязгаарлагдмал байгаатай холбогдуулан Сингапурын Эрүүл мэндийн яамнаас нийт улсын болон хувийн эмнэлгүүдийг тус улсад байнга оршин суудаггүй гадны иргэдэд үйлчлэхгүй байх зөвлөмж гаргав. Мөн одоо эмчлүүлж байгаа гадаад улсын өвчтөн нарыг өөрийн эх орондоо очиж эмчилгээгээ үргэлжлүүлэхийг зааварлаж байна.

Эх сурвалж: Гадаад харилцааны яам

Энэтхэг улс:

- 01 сарын 31-с 3 сарын дунд үеийг хүртэл коронавирус илэрсэн тохиолдлууд нь бүгд COVID-19-г өртсөн улс орнуудаас ирсэн хүмүүс, тэдгээрийн дотны хүмүүс байжээ.
- 2020 оны 01 сард Эрүүл мэндийн яамнаас “NATIONAL GUIDELINES FOR INFECTION PREVENTION AND CONTROL IN HEALTHCARE FACILITIES” зөвлөмжийг боловсруулан нийтэд түгээсэн.
- Энэтхэг улс нь гаднаас ирсэн хүмүүсийн халууныг хэмжих, бусад шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг эхний удаа шинжлэн, хариу сөрөг гарсан тохиолдолд гэртээ 14 хоног тусгаарлагдахыг сануулах ба энэ хугацаанд тогтмол зааварчилгаа өгөн, хэрэв ямар нэгэн шинж илэрсэн тохиолдолд **гэрт нь тусламж үзүүлэх бодлогыг** баримталсан байна. Өндөр халуурах, амьсгалахад хүндрэлтэй болох зэрэг шинж илэрсэн тохиолдолд эмнэлэгт хэвтүүлнэ. Гэтэл зарим хүмүүс энэхүү тусгаарлалтыг зөрчин гадуур явж байсан ба үүнтэй холбоотойгоор дотооддоо цар тахал алджээ. Иймд арилжааны, боловсролын, энтертайнмент, спортын, шашны, болон бусад үйл ажиллагаануудыг түр хугацаанд хориглож, бүх сургуулиудыг хаав. 03 сарын 3 дахь 7 хоног гэхэд Энэтхэг улсын бүх хотуудад COVID-19-н тохиолдол илэрсэн байна.
- 03 сарын 24-нээс үндэсний хэмжээнд хөл хориог тогтоосон. Ихэнх тохиолдол нь хот газруудаас илэрснийг хүн амын нягтаршилтай холбон тайлбарлажээ. Зайлшгүй бараа болон

ханган нийлүүлэлтээс бусад бүх тээвэр, хүн зорчигчдын үйл ажиллагааг зогсоосон. Хөл хориог 05 сарын 30-ны өдөр цуцалсан байна. Гэвч эрсдэл өндөртэй бүсчлэлд хөл хориог үргэлжлүүлсэн ба 10 сарын 31-с хөл хориогүй болсон.

- Халдвар авагсдын ихэнх нь, ялангуяа хүүхдүүд болон залуу хүмүүст зовиур бага байсан учир тэдгээр хүмүүсийг эмнэлэгт эмчлэх шаардлагагүй гэж үзэн, гэрээр эмчилж байсан ба энэ процесс одоо хүртэл үргэлжилж буй аж. /Гэрийн хэн нэгэн нь тухайн хүнээс дамжин халдвар авсан тохиолдолд тусгаарлалтын хугацааг нь уртасгадаг болно./ Үүний нэг давуу тал нь хүмүүс эмнэлэгт ганцаараа хэвтсэнээс үүдэх сэтгэл зүйн тогтворгүй байдал бий болохгүй гэж ард түмэн үзэж байна. Халдвар авсан хүмүүсийн 5% орчим нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн гэсэн тоо мэдээ Энэтхэгийн эрүүл мэнд, гэр бүл хамгааллын яамны сайтад дурдагджээ.
- Бусад улс орнуудын адилаар иргэддээ зайнаас харьцах, маск зүүх, маскаа 6 цаг тутамд заавал солих, гараа савандаж угаах, ариутгах зэрэг үйлдлийг хийж хэвших ёстой талаар чиглэл өгч ажиллаж байна.
- Эмнэлгийн салбарт ажиллагсдын эрүүл мэндийн даатгалд 5.0 сая рупи-г ЗГ-с төлсөн.
- Ерөнхийдөө 6 сараас хойш COVID-19-р өвчилсөн хүмүүсийн тоо ихэссэн хэдий ч бизнесийн ихэнх үйл ажиллагаа 11 сар хүртэл хэвийн үргэлжилж байна.


Эх сурвалж: <https://indianexpress.com/article/india/coronavirus-covid-19-pandemic-india-timeline-6596832/>

3. ЕВРОП

3.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Европ нь COVID-19 вирусийн нөлөөнд хамгийн их өртсөн бүс нутгуудын нэг бөгөөд 2020 оны 11-р сарын 14-ний өдрийн байдлаар нийт 13,756,317 тохиолдол бүртгэгдсэнээс 319,302 нь нас барсан /2.3%/ байжээ. Хөл хорио болон бусад хязгаарлалтуудыг тавих замаар вирусийн эхний давлагааг хязгаарлаж чадсан боловч карентинийг хэвээр үргэлжлүүлээгүй улмаас Европын бүс нутаг дараагийн давлагаанд өртсөөр байна.

График 9. Голлох орнуудын халдвар бүртгэгдсэн тохиолдол



Эх үүсвэр: ECDC

Жич: 2020 оны 11-р сарын 14-ний өдрийн байдлаар

3.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ

Франц:

Анхны тохиолдол бүртгэгдэв

- 2020.01.24 – БНХАУ-аас ирсэн 48 настай Франц улсын иргэн анхны тохиолдлоор бүртгэгдсэн бөгөөд энэ нь Европт COVID-19 эхний тохиолдол болов.

Эхний давлагаа

- 2020.02.17 – Францын зүүн хэсэгт байдаг Mulhouse хотын Христийн нээлттэй хаалганы сүмд болсон шашны үйл ажиллагаанд 2,500 гаруй хүн оролцсон бөгөөд хамгийн багадаа оролцогчдын тал нь COVID-19 халдвартай байсан /эх сурвалж: Radio France/. Халдварын эх үүсвэрийг тодорхойлох боломжгүй байсан бөгөөд энэ нь COVID-19 тархалтыг хяналтаас гаргах онцгой хүчин зүйл болсон.
- 2020.03.05-03.24 – Олноор цугларах, сургууль болоод боловсролын институцийн үйл ажиллагаа, шашны цуглалал, ресторан болон үйлчилгээний байгууллагууд, төрийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд, аялал жуулчлал, улсын хил зэргээ шат дараатайгаар хааж, хол хориг тогтоосон.
- 2020.04.01 – Өдөрт шинээр бүртгэгдэж буй вирусийн тохиолдлын тоо 7,578-д хүрэв. 4-р сард тархалт огцом өсөж 2020 оны эхний хагасын оргил цэгтээ хүрлээ.

- 2020.06.26 – Франц улсад COVID-19 тохиолдол шинээр бүртгэгдээгүй. 5 болон 6-р саруудад тусгаарлалт, хөл хорионы үр дүн гарч вирусийн тархалт саарсан.
- 2020.06.14-07.15 – Кафе, ресторан болон үйлчилгээний байгууллагууд, сургууль, их сургууль, боловсролын институцууд нээгдсэн бөгөөд Европын холбооны болон бусад улсуудад хилээ нээсэн. Франц улс Эрүүл мэндийн онц байдлаа цуцласан.

Хоёр дахь давлагаа

- 2020.08.28 – 24 цагийн дотор 7,379 шинэ тохиолдол бүртгэгдсэнээр эхний давлагааны мөн хугацаанд бүртгэгдсэн хамгийн их тохиолдлын тоог давсан бөгөөд үүнийг харгалзан олон нийтийн газар заавал амны хаалт зүүх захирамж гарсан /New Peak/.
- 2020.09.12 – Вирусийн тархалт улам нэмэгдэж Франц нэг өдрийн дотор 10,000 –с илүү тохиолдол бүртгэсэн, мөн үхлийн тоо эрс нэмэгдсэн. Байдал улам муудсан.
- 2020.10.15 – Франц улс нэг өдрийн дотор 30,000-с илүү тохиолдол бүртгэгдсэн Европын анхны улс болсон.
- 2020.10.28 – Сургууль болон үйлдвэрүүдээс бусад байгууллагуудыг хаах, хол хориог улсын түвшинд дахин хэрэгжүүлэх шийдвэрийг зарласан.

Испани:

Анхны тохиолдол бүртгэгдэв

- 2020.01.31 – Герман улсаас ирсэн нэгэн жуулчны шинжилгээний хариу эерэг гарч Испани улсад анхны тохиолдол бүртгэгдэв.

Эхний давлагаа

- 2020.02.09 – Испани улсын Эрүүл Мэндийн Онцгой Байдлын дарга Fernando Simón “Испанид цөөн тооны тохиолдол бүртгэгдэх болно” хэмээн мэдэгдсэн.
- 2020.02.10 – Их Британиас ирсэн жуулчнаас COVID-19 илэрсэн нь хоёр дахь тохиолдол болсон.
- 2020.02.13 – 100,000-с илүү хүн оролцдог MWC Barcelona арга хэмжээ цуцлагдсан.
- 2020.02.26 – Дотооддоо халдвар тарсан анхны тохиолдол бүртгэгдсэн.
- 2020.03.03 – Испанийн Эрүүл Мэндийн Яам спортын арга хэмжээ, тоглолтуудыг хаалттай хүрээнд буюу үзэгчгүйгээр явуулах захирамж гаргасан.
- 2020.03.08 – Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдрийн үйл ажиллагаанд 120,000 гаруй хүн оролцсон бөгөөд 60,000 хөлбөмбөгийн фенүүд хотын хамгийн том цэнгэлдэхийг дүүргэсэн.
- 2020.03.15 – Засгийн газраас зарласан Онц Байдал хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой зайлшгүй шаардлагагүй байгууллага болон бизнесүүдийг хааж, иргэд хоорондоо зохих зайгаа барьж явахыг зааварчилж, хөл хорио болон хязгаарлалтуудыг тавьсан. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 7,793.
- 2020.03.27 – Вирусийн тархалтын хурд оны эхний хагасын хувьд дээд цэгтээ хүрсэн. 24 цагийн дотор 9,181 шинэ тохиолдол бүртгэсэн бөгөөд үр дүнд нь нийт бүртгэгдсэн тохиолдол 75,641 болж нэмэгдсэн.
- 2020.04.03-04.11 – Шинээр бүртгэгдэх болсон нас баралтын өсөлт саармагжиж эхлэв. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 168,022.

- 2020.04.13 – Барилга болон үйлдвэрлэлийн салбарт ажилладаг, цахим суваг ашиглан ажиллах боломжгүй ажилчид эргээд ажилдаа орохыг зөвшөөрсөн бөгөөд засгийн газраас нийтийн тээврээр зорчиж байгаа хүмүүст маск тарааж эхэлсэн.
- 2020.04.28 – Засгийн газар хол хорио, хязгаарлалт болоод хилийн хаалт зэргийг эргүүлэн авах 0-3 шат бүхий төлөвлөгөөг танилцуулсан.
- 2020.06.21 – Испани улс дотоод болон гадаад хоригоо суллаж шинэ хэвийн байдалд орсон. Засгийн газраас иргэддээ хоорондын зайгаа барьж явах, амны хаалт зүүх захирамжаа эргүүлэн аваагүй.

Хоёрдахь давлагаа

- 2020.08.19 – 24 цагийн дотор 3,715 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь оны эхний сараас хойш Испани улсын нэг өдөрт бүртгэсэн хамгийн олон тохиолдол болсон. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 370,867.
- 2020.09.04 – Нэг өдрийн дотор COVID-19 вирусийн халдвар авсан нийт хүмүүсийн тоо 10,476-р нэмэгдэн 498,989-т хүрсэн нь халдварын тархац хамгийн идвэхтэй өдөр болов.
- 2020.10.21 – 45 хоногийн дотор халдвар авсан хүмүүсийн тоо хагас саяар нэмэгдсэн байна. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 1,005,295.
- 2020.10.25 – Испанийн засгийн газар хөл хориог дахин тогтоож, бусад улсууд руу аялах аяллыг хорьж, улсын хилээ хааж Онцгой Байдлыг дахин зарласан.

Их Британи:

Анхны тохиолдол бүртгэгдэв

- 2020.01.31 – Халдварын голомтоос ирсэн иргэнээс COVID-19 вирус илэрснээр Их Британийн Иорк хотод анхны тохиолдол бүртгэгдэв.

Эхний давлагаа

- 2020.03.05 – COVID-19 улмаас үхсэн хамгийн анхны тохиолдол бүртгэгдэв. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 164.
- 2020.03.13 – Их Британийн 2020 оны Орон нутгийн сонгуулийг жилийн хугацаагаар хойшлуулсан. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 1,282.
- 2020.03.18-03.20 – Засгийн газар сургууль болон боловсролын институт, ресторан, кино театр зэрэг олон нийтийн цугларах газруудыг хаасан. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 5,426.
- 2020.04.10 – Нэг өдөрт 980 үхлийн тохиолдол бүртгэгдэж нийт 8,958 үхлийн тохиолдол болов. Харин COVID-19 вирусийн нийт бүртгэгдсэн тохиолдол 76,635 болж нэмэгдсэн. Вирусийн тархалт 2020 оны эхний хагасын байдлаар хамгийн хурдацтай тархаж байсан.
- 2020.05.28 – Вирусийн тархалт саарсан бөгөөд Шотландын Ерөнхий сайд ойрын хугацаанд хол хорио, хязгаарлалтуудыг сулруулж, буулгана гэсэн мэдэгдэл гарсан. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 249,268.
- 2020.06.01 – Ерөнхий боловсролын сургуулиуд, үйлчилгээний зарим газруудыг нээсэн. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 255,515.

- 2020.07.02 – Засгийн газар 75 орны нэрийг хорионоос арилгаж зорчих, тээвэр хийх боломжтой болгов. Мөн Их Британид ирж байгаа аялагчид өөрийгөө тусгаарлах шаардлагагүй болсон. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 284,271.

Хоёр дахь давлагаа

- 2020.09.22 – 24 цагийн дотор 4,368 шинэ тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Вирусийн тархалт буцаад нэмэгдэж эхэлсэн. Засгийн газраас хязгаарлалтуудыг чангатгахаа мэдэгдэв /үйлчилгээний газруудыг оройны 10 цагаас өмнө хаах г.м/. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 398,625.
- 2020.10.22 – Засгийн газраас хөл хориог улсын хэмжээнд тогтоох, улс хоорондын хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр гаргахаар төлөвлөж байгаа гэдгээ мэдэгдсэн. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 798,229.
- 2020.11.05 – Их Британи бүрн хөл хорио тогтоолоо. Нийт COVID-19 бүртгэгдсэн тохиолдлын тоо 1,099,059.

3.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ

3.3.1. Хууль эрх зүй:

Франц – COVID-19 вирустэй холбоотой Франц улсын хууль эрх зүйн орчинд дараах голлох өөрчлөлтүүд түр болоод урт хугацаагаар орж байна. Үүнд:

- Зарим татвар, төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг хойшлуулах, буцаах, хөнгөлөх заалтууд.
- Зээл болон зээлийн шугамд баталгаа гаргах, баталгаанд хамрагдах нөхцөлүүд.
- Засгийн газар болон Францын Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээнд /Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах г.м/ хамрагдах заавар журам.
- Ажлын цагийг богиносгох, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгасан заалт.
- Хямралын үед хэрэглэгч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч зэрэг эдийн засгийн оролцогчдын маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх журам.

Испани – Бүрэн эрхийнхээ хүрээнд Испани улс Корона вирусээс үүсээд буй хямралыг зохицуулах зорилгоор авч буй арга хэмжээ нь дараах хуулиудад тусгагдсан.

- Royal Decree-Law 6/2020 - Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар яаралтай арга хэмжээ
- Royal Decree-Law 7/2020 – COVID-19 эдийн засаг, нийгмийн нөлөөллийг арилгах онцгой яаралтай арга хэмжээ
- Royal Decree-Law 463/2020 – COVID-19 улмаас үүссэн эрүүл мэндийн гамшигт нөхцөл байдлаас түгшүүрийн байдлыг зарлах тухай
- Royal Decree-Law 8/2020 – COVID-19 эдийн засаг, нийгмийн нөлөөллийг арилгах онцгой яаралтай арга хэмжээ
- Royal Decree-Law 465/2020 – COVID-19 улмаас үүссэн эрүүл мэндийн хямралын нөхцөл байдлыг зохицуулахад зориулж
- Royal Decree-Law 9/2020 – COVID-19-ийн нөлөөг бууруулах ажлын байран дахь нэмэлт арга хэмжээ

- Royal Decree-Law 10/2020 – COVID-19-ийн эсрэг тэмцлийн хүрээнд хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилгоор зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлдэггүй ажил эрхэлж буй хүмүүст нөхөн төлөгдөх цалинтай чөлөө олгохыг зохицуулсан
- Royal Decree-Law 11/2020 – Нийгэм, эдийн засагт COVID-19-тэй тэмцэх нэмэлт яаралтай арга хэмжээнүүд

Их Британи – Их Британи COVID-19-тэй тэмцэх зорилгоор ажлын цагийг богиносгох, ажлын байрыг авч үлдэхтэй холбоотой заавар, дүрэм, хууль, мөн эдийн засгийг дэмжих, хүн амыг аюулаас хамгаалахтай холбоотой хууль зэрэг олон хуулийг баталсан. Бүс нутгийн хүрээнд дараах хуулиудыг гаргажээ:

- Coronavirus Act 2020 /с. 7/
- Coronavirus /Scotland/ Act 2020 /asp 7/
- Coronavirus /Scotland/ /No.2/ Act 2020 /asp 10/
- The Health Protection /Coronavirus, Restrictions/
- The Health Protection /Coronavirus, Local COVID-19 Alert Level/

3.3.2. Сонгууль:

Франц – 2020 оны 3-р сарын 15-ны өдөр Франц улсын Орон Нутгийн сонгуулийн эхний шат зохион байгуулагдсан /46% ирцтэй байсан/. Хоёр өдрийн дараа Францын Ерөнхийлөгч Emmanuel Macron COVID-19 тархалтаас болоод хоёр дахь шатны сонгуулийг хойшлуулсан.

Испани – 2020 оны 7-р сарын 12-ны өдөр Испанийн Basque Country болон Galicia –д мужийн хоёр сонгууль болсон бөгөөд энэхүү сонгуулийг 4-р сарын 5-ны өдөр явуулахаар байсан боловч вирусийн тархалт эрс нэмэгдсэн тул хойшлуулаад байв.

Их Британи:

- 2020 оны 3-р сарын 13-ны өдөр Английн орон нутгийн сонгуулийг 2020 оны 5-р сарын 7-ны өдөр хүртэл хойшлуулсан боловч хожим 2021 оны 5-р сарын 7-ны өдөр хүртэл нэг жилийн хугацаагаар хойшилсон.
- 2020 оны 3-р сарын 30-ны өдөр Шотландын Орон нутгийн нөхөн сонгуулийг 2020 оны 5-р сарын 14-ний өдөр хүртэл хойшлуулсан боловч хожим тодорхойгүй хугацаагүйгээр дахин хойшлуулсан.

3.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ

3.4.1. Төсвийн бодлого

Note: Засгийн газрын дэмжлэгийг дараах гурван ангилалд хуваав.

- **Шуурхай санхүүгийн дэмжлэг /Immediate fiscal impulse/IFI/:** Засгийн газрын зардлын өсөлт /эмнэлгийн хангамж, хүмүүсийг ажилтай байлгах зориулалттай ЖДҮ-ийн татаас, төсвийн хөрөнгө оруулалт г.м/ ба орлогын бууралт /тодорхой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг цуцлах г.м/. Энэ төрлийн арга хэмжээ нь төсвийн тэнцэлд шууд сөргөөр нөлөөлөх ба дараа нь шууд нөхөн төлөгдөхгүй.
- **Татвар, төлбөр хойшлуулалт /Deferrals/D/:** Хэд хэдэн улс татвар, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг тодорхой төлбөрийг хойшлуулахаар шийдсэн бөгөөд үүнийг зарчмын хувьд

дараа нь буцааж төлөх ёстой. Мөн хойшлуулсан төлбөр тухайн жилдээ орж байгаа нөхцөлд энэ нь төсөвт нөлөө үзүүлэхгүй.

- **Бусад хөрвөх чадварын тусламж болон баталгаа /Other liquidity provisions and guarantees/OLPG/:** Энэ арга хэмжээнд экспортын баталгаа, хөрвөх чадварын тусламж, үндэсний хөгжлийн банкнүүдээр дамжуулан олгох зээлийн шугам орно.

Франц:

Total Immediate Fiscal Impulse = 124 тэрбум евро. Хамгийн их дүнтэй шуурхай санхүүгийн дэмжлэгүүд /IFI/-ээс дурдвал:

- 31 тэрбум евро - Хүмүүсийг ажилтай байлгах зориулалт бүхий ЖДҮ-д зориулсан дэмжлэг. Компаниуд /ЖДҮ/ ажилчдынхаа нийт цалингийн 70%, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авдаг ажилчдын хувьд 100% төлөх бөгөөд төрөөс цалингийн доод хэмжээнээс 4-5 дахин их хэмжээний нөхөн олговор олгоно.
- 21.5 тэрбум евро - Улсын татварын хөнгөлөлтийг буцаан олгох дэмжлэг. Компанийн татварын нэхэмжлэлийн 75%-100% хүртэлх хувийг нөхөн төлнө /НӨАТ орно/.
- 14 тэрбум евро – Жижиг бизнесийн санхүүжилт, ажилгүйдлийн тэтгэмж, бизнесийн үйл ажиллагаанд зориулж түрээсийн төлбөрөө бууруулсан түрээслүүлэгчдэд олгох олговор зэргийг хамарсан засгийн газрын татаас.

Total Deferrals = 210 тэрбум евро. Хамгийн их дүнтэй татвар болон төлбөрийн хойшлуулалт /D/-с гурвыг дурдвал:

- 180 тэрбум евро – Зээлийн эргэн төлөлтийн хойшлуулалт. Байгууллагын зээлийн эргэн төлөлтийг 6 сарын хугацаагаар хойшлуулсан. 177 тэрбум евро зээлийн эргэн төлөлтийг, 3 тэрбум евро хүүгийн төлбөрийг хойшлуулсан.
- 170 тэрбум евро – Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын түрээсийн төлбөрийг 3-6 сарын хугацаагаар хойшлуулсан.
- 22.5 тэрбум евро /үнэлгээ/ - Засгийн газар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах, цуцлах нийт 25.5 тэрбум еврогийн тооцоог хийсэн бөгөөд ойролцоогоор 3 тэрбум еврог цуцлах замаар барагдуулна гэж тооцоолсон тул 22.5 тэрбум евро үлдэнэ.

Total Other liquidity provisions and guarantees = 342 тэрбум евро. Хамгийн их дүнтэй хөрвөх чадварын тусламж болон баталгаа /OLPG/-с гурвыг дурдвал:

- 315 тэрбум евро - 2020 оны 12-р сарын 21 хүртэл нийт 315 тэрбум евро хүртэлх зээлийн баталгаа. Үүнд ногдол ашиг тогтвортой тараасаар байгаа томоохон компаниуд хамрагдахгүй.
- 20 тэрбум евро – Эдийн засгийн стратегийн оролцогчдод олгох зээлийн шугам.
- 6.5 тэрбум евро – Аялал жуулчлалын салбарт олгох улсаас батлан даасан зээл.

Испани:

Total Immediate Fiscal Impulse = 45.7 тэрбум евро. Хамгийн их дүнтэй шуурхай санхүүгийн дэмжлэгүүд /IFI/-с гурвыг дурдвал:

- 17.9 тэрбум евро – Ажиллах хүчийг түр хугацаанд бууруулах хөтөлбөр /ERTE/. Ажиллах хүчээ түр зогсоосон эсвэл ажиллах цагийг багасгасан компаниуд хамрагдана.
- 16 тэрбум евро – COVID-19 сан. Орон нутгийн засаг захиргааны нэгж бүрд /Autonomous communities/ олгогдон тэдгээр нь бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай зардлыг

санхүүжүүлэх /голчлон эрүүл мэнд, боловсрол болон орлогын дэмжлэгт зориулсан/ зориулалт бүхий татаас.

- 3.8 тэрбум евро – Онц байдал зарласны улмаас үйл ажиллагаагаа зогсоосон, ноцтой алдагдал хүлээсэн бизнес эрхлэгчдэд олгох дэмжлэг.

Total Deferrals = 9.7 евро. Хамгийн их дүнтэй татвар болон төлбөрийн хойшлуулалт /D/-с гурвыг дурдвал:

- 5 тэрбум евро /үнэлгээ/ – COVID-19 вирусийн улмаас зээлийн төлөлтөө хийхэд хүндрэлтэй болсон эмзэг бүлгийн иргэд хамрагдах бөгөөд тэдгээр иргэдийн Ипотекийн зээлийн төлбөрийг хойшлуулсан.
- 3.9 тэрбум евро – Хөдөлмөртэй холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэл болон хөдөлмөрийн бусад зардал, төлбөрийг хойшлуулах арга хэмжээ.
- 1.2 тэрбум евро – Компани болон түүний ашигтай холбоотой татварын төлбөрийг хойшлуулав.

Total Other liquidity provisions and guarantees = 114.4 евро. Хамгийн их дүнтэй хөрвөх чадварын тусламж болон баталгаа /OLPG/-с гурвыг дурдвал:

- 100 тэрбум евро – Зээлийг дахин санхүүжүүлэх эсвэл шинэ зээл авахтай холбоотой зээлийн батлан даалтыг гаргах. Компани болон хувиараа бизнес эрхлэгч хуулийн этгээдүүд хамрагдаж болно.
- 10 тэрбум евро – Зээлийн шугамыг нэмэгдүүлэхийн тулд Испанийн Зээлийн Институцээс цэвэр зээллэгт тавьсан хязгаарыг 10 тэрбум евро –р өсгөсөн.
- 2 тэрбум евро – Испанийн экспортын зээлийн даатгалын компаниар дамжуулан зээлийн батлан даалтыг нэмэгдүүлсэн.

Их Британи:

Total Immediate Fiscal Impulse = 176.7 тэрбум фунт. Хамгийн их дүнтэй шуурхай санхүүгийн дэмжлэгүүд /FI/-с гурвыг дурдвал:

- 54 тэрбум фунт – COVID-19 хямралын үед ажлын байрыг хадгалж үлдэх хөтөлбөр.
- 31.9 тэрбум фунт – Эрүүл мэндийн үйлчилгээ, Вирусийг илрүүлэх техник, тоног төхөөрөмж түүнтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилготой.
- 15 тэрбум фунт – Жижиг, дунд бизнест буцалтгүй тусламж.

Total Deferrals = 50 тэрбум фунт. Хамгийн их дүнтэй татвар болон төлбөрийн хойшлуулалт /D/-с гурвыг дурдвал:

- 50 тэрбум фунт – НӨАТ болон орлогын албан татварын хойшлуулалт.

Total other liquidity provisions and guarantees = 340.3 тэрбум фунт. Хамгийн их дүнтэй хөрвөх чадварын тусламж болон баталгаа /OLPG/-с гурвыг дурдвал:

- 330 тэрбум фунт – Корона Вирусийн нөлөөний улмаас зогссон бизнесийг сэргээх, Том компанийн үйл ажиллагаа зогссоныг санхүүжүүлж үйл ажиллагааг үргэлжлүүлэх, Корпорацын санхүүжилтийн зээл зэрэгт ашиглаж болох зээлийн батлан даалт.
- 10 тэрбум фунт – Бизнесийн байгууллагуудын хооронд шууд хийгддэг /зуучлагчгүй/ ажил гүйлгээг дэмжихийн тулд худалдааны зээл болон авлагын даатгалд зориулсан.
- 0.3 тэрбум фунт – Соёлын салбарт зээлийн дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий засгийн газрын татаас.

3.4.2. Мөнгөний бодлого

Европын Төв Банк /ЕСВ/

Interest rate policy - 2020 оны 3, 4, 6, 7, 9-р саруудад Удирдлагын хороо хуралдсан боловч бодлогын хүү болоод бусад хэрэгслүүдийн хүүг хэвээр үлдээсэн.

- Үндсэн дахин санхүүжүүлэх үйл ажиллагаа /MRO/: 0.00% /2016 оны 3-р сараас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд дахин санхүүжүүлэх үйл ажиллагаа нь Европын банкны системийн хөрвөх чадварт чухал нөлөө үзүүлдэг/.
- Marginal Lending Facility: 0.25% /2016 оны 3-р сараас хойш өөрчлөгдөөгүй/.
- Deposit facility: -0.50% /2019 оны 9-р сараас хойш өөрчлөгдөөгүй, Европын банкнууд Төв банкнаас Овернайт зээл авахад ашиглах хүү болж өгдөг/

Asset Purchase Program /Quantitative Easing, QE/ – Энэ нь Төв банкны стандарт бус бодлогын хэрэгсэл бөгөөд дараах үе шаттай арга хэмжээг ЕСВ авсан:

- **PEPP** 750 тэрбум евро – 2020 оны 3-р сарын 18-ний өдөр Төв банкны Удирдах зөвлөлийн хуралдаанаар Pandemic Emergency Purchase Program /PEPP/ –г баталсан бөгөөд энэ нь улсын болон хувийн секторт зориулсан арга хэмжээ юм.
- **PEPP** 600 тэрбум евро – 2020 оны 6-р сарын 4-ний өдрийн Хуралдаанаар Төв банк PEPP арга хэмжээг эрчимжүүлж худалдаж авах хэмжээг 1.35 их наяд евро хүртэл нэмсэн /2020 оны 9-р сар гэхэд PEPP –н хүрээнд 500 тэрбум еврогийн худалдан авалт хийгдсэн/.
- **APP** 120 тэрбум евро – 2020 оны 3-р сарын 12-ны өдрийн Хурлаар Asset Purchase Program /APP/ –н худалдан авах дүнг 120 тэрбум еврогоор нэмэгдүүлэх шийдвэрийг баталсан. 2020 оны 3-8 сарын хооронд 207.3 тэрбум еврогийн худалдан авалт APP хүрээнд хийгдсэн.

Long-term Refinancing Operations – 2020 оны 3 болон 8-р сарын хуралдааны шийдвэрээр ЕСВ –ны Урт Хугацаат Дахин Санхүүжилтийн Хөтөлбөрт /LTRO/ томоохон өөрчлөлтүүд орсон.

- 388.9 тэрбум евро Long-term Refinancing Operations /LTRO/ – 2020 оны 3-р сарын 12 –ны өдрийн хурлаар LTRO хөтөлбөрийг түр хугацаанд эрчимжүүлэх шийдвэр гаргасан бөгөөд 2020 оны 6-р сарын 10-ний өдөр гэхэд 388.9 тэрбум еврогийн дахин санхүүжилт олгогдсон. Үүнд санхүүжилтийн өртөг буюу хүүгээр Deposit facility хүүг ашиглана.
- 1.3 их наяд евро Targeted Longer-term Refinancing Operations /TLTRO/ – 2020 оны 3-р сарын 12-ны хурлаар Европын Төв банк өмнө нь хэрэгжүүлээд байсан TLTRO хөтөлбөрийг дахин эхлүүлсэн бөгөөд энэ нь LTRO хөтөлбөртэй адилхан боловч зорилгод бүлэгт санхүүжилтийн зардал буюу хүүний хувийг бууруулдаг ялгаатай.
- 22.9 тэрбум евро Pandemic Emergency LTRO /PELTRO/ – 2020 оны 4-р сарын 30-ны өдрөөс Төв банк барьцаа хөрөнгийн шаардлагыг зөөлрүүлэх арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хүүний хувьд MRO хүүгээс 0.25 хувиар бага.

Collateral Framework – 2020 оны 4-р сарын 7-ны өдөр Барьцаа хөрөнгийн шаардлагыг түр хугацаанд сулруулах хөтөлбөр /Package of temporary collateral easing measures/ хэрэгжиж эхэлсэн. Үүнтэй холбоотой дараах онцлох өөрчлөлтүүд орсон.

- Барьцаа хөрөнгийн үнэлгээний хорогдуулгыг 20 хувиар бууруулах, Европын системийн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээг /level of risk tolerance/ нэмэгдүүлэх.
- Нийт барьцааны багцад эзэлж болон барьцаагүй өрийн хэрэгслийн хэмжээг 2.5 хувиас 10 хувь болгож нэмэгдүүлсэн г.м.

Английн банк /Bank of England/

Interest Rate Cut in two stages to 0.1% - 2020 оны 3-р сарын 11-ний шийдвэрээр бодлогын хүүг 0.75% -с 0.50% бууруулж 0.25% болгосон бол 3-р сарын 19-ний Хурлаар дахих 0.15% бууруулж 0.10% болгосон. Эдгээр шийдвэрүүд нь

Expanded quantitative easing:

- 200 тэрбум фунт – 2020 оны 3-р сарын 19-ний өдөр Английн төв банк 645 тэрбум фунтын нийт хөрөнгийг өөртөө аван, 200 тэрбум фунт банкнуудад нийлүүлэхээр болсон.
- 100 тэрбум фунт – 2020 оны 6-р сарын 18-ний өдөр Төв банк нийт 745 фунт хөрөнгийг өөртөө аван 100 тэрбум фунтыг гаргасан.
- 150 тэрбум фунт – 2020 оны 11-р сарын 5-ны өдөр Английн Төв банк нэмж 150 фунтын хөрөнгийг худалдаж авсан.

Other Measures to Support Lending:

- Хугацаат Санхүүжилтийн Хөтөлбөр /Term Funding Scheme/ – 2020 оны 3-р сарын 11-ний өдөр, бодлогын хүүг бууруулах нь зарим банк, санхүүгийн байгууллагад хүндрэлтэй тусаж болзошгүй тул үүнээс сэргийлэх, мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор бодит эдийн засгийг дэмжих чиглэлд олгосон зээлийн 5 хувиас дээш хэсэгт санхүүжилт жилээс дээш хугацаатай олгох. Хүүгийн хувьд бодлогын хүүтэй ойролцоо байна.
- Lower amount of required reserves – 2020 оны 3-р сарын 11-ний хурлаар Санхүүгийн Бодлогын Хороо Английн “Countercyclical capital buffer rate” –г 0% болгосон.


4. ХОЙД АМЕРИК

4.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хойд Америк тив нь COVID-19 вирусийн нөлөөнд хамгийн их өртсөн бүс нутгуудын нэг бөгөөд 2020 оны 11-р сарын 18-ний өдрийн байдлаар нийт 13,939,046 тохиолдол бүртгэгдсэнээс эдгэсэн тохиолдлын тоо 8,726,080 /62.6%/, нийт нас барсан тохиолдлын тоо 382,582 /2.7%/ байна. Хөл хорио болон бусад хязгаарлалтуудыг тавих замаар вирусийн эхний давлагааг хязгаарлаж чадсан боловч хөл хориог хэвээр үргэлжлүүлээгүй, олон нийтийн зан төлвийн томоохон өөрчлөлт /жагсаал цуглаан, эсэргүүцлийн хөдөлгөөн/ зэргээс үүдэж Хойд Америк тивийн бүс нутаг дараагийн давлагаанд өртсөөр байна.

АНУ-д бүртгэгдсэн тохиолдлын тоо 11,085,184 байгаа нь Хойд Америк тивд нийт бүртгэгдсэн тохиолдлын 79.5 хувийг эзэлж байгаа ба тус улсад нас барсан тохиолдлын тоо 245,164 байгаа нь Хойд Америк тив дэх нас барсан тохиолдлын 64.0 хувийг эзэлж байна. АНУ-д нас барагсдын тоо өндөр байгаа ч нийт халдвар авсан хүмүүсийн 2.2 хувийг эзэлж байгаа бол харин, Мексикт нас баралтын хувь хамгийн өндөр буюу 9.8 хувь байна.

График 10. Голлох орнуудын халдвар бүртгэгдсэн тохиолдол



Эх сурвалж: ДЭМБ

АНУ

АНУ-ын хувьд COVID-19 цар тахалд хамгийн хүндээр нэрвэгдээд байгаа улс бөгөөд 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар нийт 166.33 сая хүнд тест хийсэн бөгөөд тэдгээрийн 8% буюу 12.6 сая хүн корона вирус халдвар авсан нь батлагдаад байгаа юм. Сүүлийн үед корона вирус халдвар маш өндөр хурдаар тархаж байгаа бөгөөд 1 долоо хоногийн дотор шинээр халдвар авсан хүний тоо 1 саяаар нэмэгдээд байна. Мөн эмнэлэгт хэвтэгсдийн тоо 11 дүгээр сарын 16-ны байдлаар 73,014-т хүрсэн нь корона вирус халдвар эхэлснээс хойшхи хамгийн өндөр дүн болоод зогсохгүй зун, намар бүртгэгдсэн дүнгээс хамгийн багадаа 10 мянгаар өндөр үзүүлэлт болж байна. Шинээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо сүүлийн байдлаар дунджаар өдөрт 3500-аар нэмэгдэж байна. Халдвар эрчимтэй нэмэгдэж байгаатай холбоотой эрх баригчид оршин суугчиддаа хэдэн долоо хоног гэртээ байх уриалгыг гаргаад байна.

АНУ дахь COVID-19 цар тахал муж тус бүрд өөр өөр цаг хугацаанд өөр өөр арга замаар нөлөөлсөн. Зарим муж хотын хувьд корона вирусын хүчтэй дэгдэлт өрнөж улмаар тархалтын хурд буурч байхад зарим газар халдварын батлагдсан тохиолдол төдийлөн бага байх үед бусад муж хотуудад халдварын тархалт нэмэгдэж эхэлж байв. Хэдийгээр зарим бүсэд батлагдсан халдварын тохиолдол болон нас баралт буурч байсан ч олон нийтийг хамарсан арга хэмжээ болон асрамын газар зэрэг бага хэмжээний нэгдэлд байгаа халдвартай нэг хүнээс маш олон хүнд халдвар тархсан тохиолдлууд үргэлжилсээр байв.

Канад улс

2020.1.27-ны өдөр Канад улсын COVID-19 анхны тохиолдол илэрсэн нь БНХАУ-ын Ухань мужаас Торонто хотод эргэн ирсэн хүнээс байжээ. 2020 оны 3 дугаар сар хүртэл Канад улсад илэрсэн тохиолдлууд гаднаас тээвэрлэгдсэн байсан. Одоогийн байдлаар халдвар авсан хүний тоо 300 мянгад хүрээд байгаа бөгөөд нийт халдварын 80 орчим хувь нь хамгийн хүн амын төвлөрөл ихтэй Кубек болон Онтарио мужуудад илэрсэн. Канад улсад халдварын шинэ тохиолдлууд есдүгээр сараас аажмаар нэмэгдэж эхэлсэн бөгөөд эхний давлагаатай харьцуулахад тархалтын хурд 3 дахин өндөр байна. Харин эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдийн тоо мөн есдүгээр сараас нэмэгдэж эхэлсэн ч өнгөрсөн хавартай харьцуулахад харьцангуй бага байна.

Мексик улс

Мексик улсад COVID-19 халдварын анхны 3 тохиолдол бүртгэгдсэн хоёрдугаар сард бүртгэгсэн бөгөөд түүнээс хойш талхалт эрчимжиж долдугаар сард оргилдоо хүрсэн бөгөөд улмаар аажмаар буураад байсан ч 10 дугаар сараас дахин эрчимжиж эхлээд байна. Хэдийгээр батлагдсан тохиолдол 1 саяд хүрээд байгаа бодит байдал дээр халдвар авсан хүний тоо үүнээс илүү байгаа гэж үзэж байгаа. Учир нь тус улсын хувьд одоогийн байдлаар 2.5 сая хүнд тестээр оншилсон бөгөөд энэ нь нийт хүн амын дөнгөж 1.9 хувь юм. Мексикт зөвхөн хүндээр өвдсөн, халдвар авсан байж болзошгүй хүнд л шинжилгээ хийх бодлого баримталж байгаа нь халдварын тархалтыг эрт барьж авах, тодорхойлоход хүндрэл учруулж байна. Хөгжиж буй тус улсын хувьд эдийн засаг нь хэдхэн төрлийн санхүүгийн нөөцөөс хамааралтай бөгөөд нийт хүн амын тал орчим хувийг ядуу, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс эзэлдэг юм.

4.2. ЭРҮҮЛ МЭНД, ОНЦГОЙ БАЙДАЛ

АНУ:

2020 оны 11 дүгээр сарын байдлаар АНУ-д COVID-19 10,800,000 гаруй тохиолдол бүртгэгдсэнээс 245,000 нь нас барсан байна. 2020.1.20-ны өдөр АНУ-ын COVID-19 анхны тохиолдол илэрсэн нь БНХАУ-ын Ухань мужаас 2020.1.15-ны өдөр гэр бүлийнхэндээ айлчлаад ирсэн хүнээс байжээ. Хоёр дахь тохиолдол нь 2020.1.24-ний өдөр илэрсэн нь БНХАУ-ын Ухань мужаас Чикаго хотод эргэн ирсэн нэгэн эмэгтэй байв. Тухайн эмэгтэй вирусыг нөхөртөө халдааснаар нөхөр нь 1.30-ны өдөр бүртгэгдсэн нь дотооддоо алдсан анхны тохиолдол байлаа.

Хоёрдугаар сар гарснаас хойш АНУ-ын гурван ч томоохон агаарын тээврийн компаниуд АНУ-БНХАУ чиглэлийн нислэгээ зогсоож, АНУ-ын иргэдийг эргүүлэн татах нислэгүүдийг л үйлдэх болжээ.

2020.2.2-ны өдрөөс ерөнхийлөгч Трамп хил хорио тогтоож, БНХАУ-д сүүлийн 2 7хоног байсан гадаадын иргэдийн АНУ-д нэвтрэхийг хориглож, БНХАУ-ын Хүбэй мужаас нутаг буцаж буй АНУ-ын иргэдийг 14 хоногийн тусгаарлалтад байлгахаар шийдэв.

2020.3.20-ны байдлаар Европын 28 орнуудад зорчсон гадаадын иргэдийг АНУ-ын хилээр нэвтрүүлэхийг хориглож эхлэв.

2020.3.13-ны өдөр ерөнхийлөгч Трамп үндэсний онцгой байдал зарлаж, 3 сарын дундуур хүртэл хүлээсний эцэст их хэмжээний эрүүл мэндийн хангамжийн материал худалдаж авах болов. Муж, бүс, омгийн болон орон нутгийн төрийн байгууллагууд онцгой байдал зарлаж, боловсролын байгууллага, олон нийтийн цугларах газрын хаав.

2020.3.27-ны өдрийн байдлаар бүртгэгдсэн хүний тоо 100,000-д хүрчээ.

Гурав болон дөрөвдүгээр саруудад, хэд хэдэн муж, хот, дүүргийн төрийн байгууллагууд вирусны тархалтыг саармагжуулах зорилгоор ард иргэдээ гэртээ байхыг уриалж эхлэв. ерөнхийлөгч Трампыг эрүүл мэндийн хангамжийн материал нэмж авахыг шаардаж эхлэв.

2020 оны 4-р сарын дундаас эхлэн, АНУ-ын хэд хэдэн мужид засгийн газрын хөл хорил хязгаарлахыг эсэргүүцсэн жагсаал болов. Prestige Ameritech компанийн эзэмшигч АНУ-ын Эрүүл мэндийн газар /HHS/-т хандан N95 маскийг сард сая, саяар үйлдвэрлэх хүчин чадалтайгаа мэдэгдсэн ч засгийн газар үүнийг ойшоогоогүй байна. American Medical Association and American Nurses Association зэрэг эрүүл мэндийн байгууллагууд

2020 оны 5-р сарын сүүлээр цагдаагийн хүчирхийлэл Жорж Флойдын үхэлд хүргэсний эсрэг 200 гаруй хотод жагсаал болсон нь вирусны тархалтыг даамжруулах аюулд хүргэв.

2020.5.14-ны өдөр засгийн газар намрын улирал гэхэд 300 сая N95 масктай болсон байхаа мэдэгдэж байсан ч 9 дүгээр сарын сүүл гэхэд ердөө 87.6 сая N95 маскын нөөцтэй байжээ.

10-р сарын эхээр эдийн засаг нээгдэж, бизнесүүд үйл ажиллагаагаа хязгаарлагдмал хүрээнд үргэлжлүүлэх болов. Сургуулиуд ангиар, цахимаар, зарим нь холимог байдлаар орох болсон ч хэд хэдэн багш, сурагчид COVID-19 вирусээр халдварласан нь тогтоогдсон тул сургуулиуд эргэн хаагдах болов.

Хоёр дахь давлагаа

Хэдийгээр тус вирусны вакцин байхгүй учир зай барих, маск зүүх болон гараа тогтмол ариутгах зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байсан ч эдийн засгаа дахин нээж эхэлсэнтэй холбоотойгоор зарим хүмүүс халдвараас урьдчилан сэргийлэх анхаарал болгоомжоо сулруулж эхэлсэн. Улмаар халдварын тохиолдлын тоо болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо нэг долоо хоног хоёр долоо хоногийн дараагаас өсөж эхэлсэн.

АНУ-д корона вирусны хоёр дахь давлагааг намрын улирал болохоос өмнө эхэлсэн гэж үзэж байгаа бөгөөд хоёр дахь давлагаа үүсэхэд хүн амын зан төлөв голлох хэсэг нь болсон гэж үзэж байгаа. Зан төлөвийн томоохон өөрчлөлтийн /жагсаал цуглаан, эсэргүүцлийн хөдөлгөөн/ нөлөө хэдэн долоо хоногийн дараагаар мэдрэгдэж эхлэх бөгөөд зургаадугаар сарын COVID-19 вирусны батлагдсан тохиолдлын өөрчлөлт нь дөрөвдүгээр сарын үйл явдлын тусгал юм. /Since then, we've had better weather, Passover, Easter, Mother's Day and Memorial Day одоо хэрхэн нөлөөлж болох талаар бодох./

Канад улс:

2020.1.27-ны өдөр Канад улсын COVID-19 анхны тохиолдол илэрсэн нь БНХАУ-ын Ухань мужаас Торонто хотод эргэн ирсэн хүнээс байжээ. 2020 оны 3 дугаар сар хүртэл Канад улсад илэрсэн тохиолдлууд нь гаднаас ирсэн хүмүүсээс байсан бол 2020.3.5-ны өдөр дотроо алдаж эв.

Гуравдугаар сарын дунд гэхэд Канад улсын бүх мужууд онцгой байдал зарлаж, сургууль, өдөр өнжүүлэх газруудыг хааж, олон хүн цуглахыг хориглож, нэн шаардлагатайгаас бусад бизнесүүдийг хааж, ард иргэдийг өөрөө тусгаарлахыг шаардаж эхлэв.

2020.4.28-ны өдөр ерөнхий сайд Трюдо эдийн засгаа дахин нээх эрүүл мэндийн арга хэмжээгээ танилцуулж, бүх мужын хил хориог 5-р сар гэхэд эргүүлэн нээх нарийвчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэв. Гэсэн ч дахин бүртгэгдэх шинэ тохиолдлууд нь Кубек, Онтарио мужуудыг хорио цээрийг чангатгахад хүргэв.

Хоёр дахь давлагаа

Канад улсын хамгийн хүн амын төвлөрөл ихтэй Кубек болон Онтарио мужууд нийт батлагдсан тохиолдлын 80 орчим хувь нь бүртгэгдсэн бөгөөд тус мужуудад нас баралт болон халдварын шинэ тохиолдол нэмэгдсэнтэй холбоотойгоор ДЭМБ-аас Канад улсыг корона вирусын хоёр дахь давлагаа гарч байгаа талаар анхааруулсан. Тус улсын халдварын тодиолдол долдугаар сарын дундуур гэхэд хэдхэн зуун шинэ тохиолдолд бүртгэгдэж байсан бол одоогийн байдлаар халдварын шинэ тохиолдолд эрчимжиж өдөрт 2200 гаруй шинэ тохиолдол бүртгэгдээд байна. Канад улсын батлагдсан халдварын тохиолдол 300 мянга хүрсэн бөгөөд сүүлийн үеийн шинэ халдварын тохиолдол хавар болж өнгөрсөн эхний давлагаатай харьцуулахад 3 дахин өндөр байгаа юм. Тус улсын хувьд 94 хоногт 50 мянга дахь халдварын тохиолдол бүртгэгдсэн бол 250,000-аас 300,000 хүрэхэд ердөө 12 өдөр зарцуулагдсан байна. 11 дүгээр сарын 9-нд нэг өдөрт батлагдсан халдварын хамгийн өндөр тохиолдол буюу 6548 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо дөрөв болон тавдугаар сард оргил үедээ буюу ойролцоогоор 3000 гаруйд хүрч байсан бол түүнээс хойш аажмаар буурсаар найм сарын сүүл есдүгээр сарын эхэн үед 230 орчимд хүрээд байсан юм. Харин есдүгээр сарын сүүлээс тасралтгүй нэмэгдэж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 1800 орчимд хүрээд байна.

Өнгөрсөн долоо хоногийн сүүлээр тус улсын ерөнхий сайд сүүлийн үед нэмэгдээд байгаа корона вирусын тохиолдол тус улсын эмнэлэгүүд болон эрүүл мэндийн ажилчидад маш их дарамт болж байгаа талаар мэдээлсэн. *Canada's public health officer Theresa Tam says COVID-19 deaths and hospitalizations likely to rise over next few weeks.*

Мексик улс:

2020.11.14-ний өдрийн байдлаар Мексик улсад COVID-19 вирусын 991,835 тохиолдол бүртгэгдсэний 97,056 нь нас барсан байна. 2020.2.28-ны өдөр Мексик улсын анхны 3 тохиолдол бүртгэгдсэн нь Итали улсад аялаад ирсэн хүмүүс байлаа. Гуравдугаар сарын сүүл гэхэд бүртгэгдсэн 1,094, нас барсан 28 тохиолдол байв. Эрүүл мэнд, эрчим хүч, нийтийн хэрэгцээний зэрэг нэн чухал үйл ажиллагаануудаас бусдыг 3-4 сарын хооронд зогсоов.

2020.3.24 – Ерөнхийлөгч Лопез Обрадор Мексик улсыг COVID 19-ийн 2-р шатанд орсныг зарлаж, онцгой горимд 2020.4.30-ны өдрөөс эхлэн орох болсныг мэдэгдэв. 100-аас дээш тооны хүмүүсийг нэг дор цуглахыг хориглож, гүйцэтгэлийн ажлыг Мексикийн арми, Мексикийн усан цэрэгт даалгав.

2020.5.18-6.30 – Мексик улсын эдийн засгийн үйл ажиллагааг тогтворжуулах эргүүлэн нээх 3 шатлалт төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэв. Мексик хотын хувьд бар шөнийн цэнгээний газруудыг хавар хаах шийдвэр гаргаад байсан ч дараа нь зарим ресторануудыг нээх шийдвэр гаргасан юм.

Долдугаар сарын дунд гэхэд 24 мужийн засгийн газар олон нийтийн газар маск зүүхийг шаардах болов.

Хоёр дахь давлагаа

Мексик улсын COVID 19-ийн халдварын тохиолдолд өнгөрөгч амралтын өдөр 1 саяын босгыг давсан бөгөөд бодит байдал дээр үүнээс их байгаа талаар албаныхан зөвшөөрч байгаа юм. Учир нь 11 дүгээр сарын 1, 2-нд болж өнгөрсөн Day of Dead багт наадмын үеэр улс даяар хэдэн зуугаараа өргөн тэмдэглэсэн бөгөөд тухайн үел явдалтай холбоотойгоор COVID 19-ийн өөр нэгэн давлагааны шалтгаан болж болзошгүйг анхааруулаад байгаа юм.

Улмаар COVID-19-ийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүний тоо наймдугаар сараас хойш байгаагүйгээр нэмэгдсэнтэй холбоотойгоор Мексик хотод бар цэнгээний газрыг 2 долоо хоногийн турш хаах шийдвэр гаргаад байна. Одоогийн байдлаар Мексик хотод хэвтэн эмчлүүлж байгаа 3000 гаруй өчтөн байгаа. Мөн Мексик хотын хувьд хамгийн өндөр буюу улаан түвшинд буюу нэн чухал биш бизнесүүдийг хаах хол хорионы дэглэмд буцаж шилжих эрсдэлтэйг албаныхан анхааруулсан.

Тус баяртай холбоотойгоор шинэ халдварын тоо болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн тоо өссөнтэй холбоотойгоор эрүүл мэндийн яамнаас вирусын хоёр дахь давлагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор оршин суугчиддаа 10 дээш хүнтэй цугларалтаас зайлсхийхийг зөвлөж байна. Мөн тестийн тоог нэмэгдүүлж өдрийн 10,000 хүргэхээр болсон ч бусад ихэнх хөгжсөн орнуудтай харьцуулахад нилээдгүй бага хэвээр байсаар байна. Мексик даяар зөвхөн хүнд амьсгалын замын өвчтэй /serious symptoms/ хүмүүст л тест хийх бодлого мөрдөгдсөөр байгаа юм.

4.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨР, НИЙГЭМ

4.3.1. Төсвийн бодлого:

АНУ:

- 483 тэрбум ам.доллар – Цалин хамгаалах төсөл, Эрүүл мэндийн хамгааллыг бэхжүүлэх акт
 1. 321 тэрбум ам.долларыг жижиг бизнест чиглэсэн, ажилтнуудаа авч үлдэх зээл, дэмжлэг
 2. 62 тэрбум ам.долларыг жижиг бизнест зээл олгоход
 3. 75 тэрбум ам.долларыг эмнэлэгт
 4. 25 тэрбум ам.долларыг вирус тестлэх ажилд
- 2.3 их наяд ам.доллар /ДНБ-ний 11%/ – Коронавирусын эсрэг, эдийн засгаа хамгаалах акт /“CARES Act”/.
 1. 293 тэрбум ам.долларыг хувь хүмүүс татварын нөхөн олговорт
 2. 268 тэрбум ам.долларыг ажилгүйдлын тэтгэмжид
 3. 25 тэрбум ам.долларыг эмзэг давхаргын бүлэгт хүнс тараахад
 4. 510 тэрбум ам.долларыг компанийн дампуурлаас сэргийлж, зээл олгох, хойшлуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд
 5. 349 тэрбум ам.долларыг өршөөж болох нөхцөлт зээлийг жижиг бизнест олгож, ажилтнуудаа авч үлдэхэд туслах
 6. 100 тэрбум ам.долларыг эмнэлэгт
 7. 150 тэрбум ам.долларыг орон нутгийн засгийн газрын шилжүүлэгт
 8. 49.9 тэрбум ам.долларыг олон услын дэмжлэгт
- 8.3 тэрбум ам.доллар – COVID 19-ийн бэлтгэл хангах болон хангамжийн материал бэлтгэх акт
- 192 тэрбум ам.доллар – Гэр бүлд дэмжлэг үзүүлэх акт

Канад улс:

- 354 тэрбум кан.доллар /ДНБ-ний 16.4%/ – татвар болон зарцуулалтад
- 20 тэрбум кан.доллар /ДНБ-ний 0.9%/ – эрүүл мэндийн салбарт
- 249 тэрбум кан.доллар /ДНБ-ний 11.6%/ – иргэд, аж ахуйн нэгжүүдэд

- 85 тэрбум кан.доллар /ДНБ-ний 3.9%/ – урсгал дэмжлэгт, татвар хойшлуулалтад

Мексик улс:

- Эрүүл мэндийн яаманд шаардлагатай арга хэмжээ авч, хангамжийн материал худалдан авахад /ДНБ-ний 0.2%/
- Иргэд, аж ахуйн нэгжүүдэд /ДНБ-ний 0.5%/
- Кредит, урсгал зардал, санхүүгийн зах зээлийг дэмжихэд
- Тендерийн үйл явцыг хурдасгахад

4.3.2. Мөнгөний бодлого:

АНУ:

- 2020.3.3-д Холбооны нөөцийн сан зорилтот хүүг 1.75%-аас 1.25% болгож бууруулав.
- 2020 оны гуравдугаар сарын 3-нд Холбооны нөөцийн сан хуралдаж бодлогын хүүгээ 50bsp-оор бууруулж 1.25 хувь болгох шийдвэр гаргасан.
- 2020 оны гуравдугаар сарын 15-нд Холбооны нөөцийн сан ахин ээржит бусаар хуралдаж бодлогын хүүг 0.25 хувь хүртэл бууруулж, 700 тэрбум долларын бонд худалдан авах программыг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.
- Холбооны нөөцийн сан CARES Act холбоотойгоор зээл гаргалтыг дэмжих арга хэмжээг авсан.
- Federal Reserve also introduced facilities to support the flow of credit, in some cases backed by the Treasury using funds appropriated under the CARES Act
- 2020 оны гуравдугаар сарын 17-нд Холбооны нөөцийн сан эдийн засаг дахь зээлийн урсгалыг үргэлжлүүлэх зорилгоор 1 их наяд долларын хэмжээ бүхий аж ахуй нэг байгууллагын гаргасан өрийн бичгийг худалдан авах үйл ажиллагааг эхлүүлсэн.
- 2020 оны гуравдугаар сарын 23-нд Холбооны нөөцийн сан тоо хэмжээний хязгаарлалтгүйгээр бонд худалдан хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөрөнгөөр баталгаажсан зээлийн үйл ажиллагааг дахин сэргээж, буцаан худалдах нөхцөлтэй зээлийн хүүг 0.1 хувиас бууруулж 0.0 хувьд болгосон.
- Арилжааны банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг 8 хувьд болгож бууруулсан.
- Fannie Mae болон Freddie Mac ипотекийн зээлтэй зээлдэгчиддээ туслах зорилгоор 12 сарын турш зээлийг царцаах, зээл төлөөгүйтэй холбоотой гарах шимтгэлийг төлүүлэхгүй байх болон зээлийн мэдээллийн санд мэдээллэхгүй байх зэрэг арга хэмжээнүүдийн хэрэгжүүлж эхэлсэн.

Канад улс:

- Канадын төв банк гуравдугаар сарын 4 болон 13 тус тус хуралдаж бодлогын хүүгээ нийт 100bsp-оор бууруулж, 0.75 хувьд хүргэсэн.
- Канадын төв банк гуравдугаар сарын 27-ны өдөр ахин хуралдаж бодлогын хүүгээ 0.25 хувьд хүргэсэн.
- Бонд худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлэ эхэлсэн.
- Хугацаат РЕПО санхүүжилт авах боломжтой баталгаа хөрөнгийн жагсаалтын нэмэгдүүлсэн.
- Канадын Ипотекийн бондын захыг дэмжих зорилгоор хоёрдог захаас бонд худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлсэн.
- OSFI зохицуулагч байгууллагаас D-SIBs эрсдэлээс жигнэсэн активын харьцааг 2.25 хувиас 1.0 хувь хүртэл бууруулсан.
- Засгийн газраас Canada Mortgage and Housing Corporation /CMHC/-ын 150 тэрбум долларын баталгаат моргейжын багцыг худалдан авахаа мэдэгдсэн.

- launching the Bankers' Acceptance Purchase Facility
- Холбооны засгийн газраас аж ахуй нэгжүүдэд туслах зорилгоор 95 тэрбум долларын зээлийн багц хэрэгжүүлсэн.

Мексик улс:

- Мексикийн төв банк 2020 оны гуравдугаар сараас хойш бодлогын хүүгээ 275bsp-оор бууруулж 4.25 хувьд хүргэсэн.
- Санхүүгийн системийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 750 тэрбум песо буюу ДНБ-ны 3.3 хувьтай тэнцэх хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлсэн.
 - Төв банк заавал байлгах зохицуулалттай хадгаламжийг /50 тэрбум песо буюу одоогийн хувьцааны 15 орчим хувь/ бууруулсан.
 - Төв банк нь банкуудын хөрвөх чадвар нэмэгдүүлэх зорилгоор илүү өргөн хүрээний барьцааг хүлээн авч, шаардлага хангасан байгууллагуудын хүрээг өргөжүүлсэн.
 - Төв банк 100 тэрбум песо хүртэлх засгийн газрын үнэт цаасны нээлттэй зах зээлийн үйл ажиллагаатай харьцуулахад илүү урт хугацаатайгаар дахин худалдаж авах боломжтой болгосон.
- Төв банк Холбооны нөөцийн банктэй 60 тэрбум ам.долларын своп эрх нээсэн.


4.4. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ

АНУ

Хойд Америкийн улсуудын хувьд цар тахал энэ оны II болон III улиралд хүчтэй нөлөөлж, өмнө нь түүхэндээ байгаагүйгээр эдийн засгийн хувьд уналт, хямралтай нүүр тулгарсан байна.

АНУ-ын ДНБ 2020 оны II улиралд 9 хувь, III улиралд 2.9 хувиар тус тус буурсан бөгөөд энэ нь цар тахалтай холбоотойгоор 2010 оноос хойш анх удаа эдийн засаг нь агшсан тохиолдол болсон.

График 11. АНУ-ын инфляци болон ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: *Tradingeconomics.com*


2020 оны 4-р сард ажилгүйдлийн түвшин 1 сарын дотор 10 орчим хувиар огцом нэмэгдэж 14.7 хувьд хүрсэн бөгөөд 4-р сараас хойш аажмаар буурсаар 10-р сард 6.9 хувь болсон хэдий ч цар тахлаас өмнөх үед 3.5 хувь байсантай харьцуулахад энэ нь хамаагүй өндөр үзүүлэлт юм.

2020 оны 10-р сарын байдлаар инфляцийн түвшин өмнөх сараас 0.2 хувиар буурч 1.2 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд хоол хүнс болон согтууруулах бус ундааны үнэ голлон нөлөөлжээ.

Мексик улс

Мексик улсын ДНБ 2020 оны I улиралд 1.2 хувь, II улиралд 17.1 хувиар тус тус буурч түүхэндээ хамгийн доод түвшиндээ хүрсэн бол III улиралд эргэн сэргэж 12 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд үйлдвэрлэлийн салбар 22 хувь, үйлчилгээний салбар 8.6 хувиар өмнөх улирлаас өссөн нь голлон нөлөөлжээ.

График 12. Мексик улсын инфляци болон ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Tradingeconomics.com


2020 оны 9-р сарын байдлаар ажилгүйдлийн түвшин өмнөх сараас 0.1 хувиар буурч 5.1 хувь болсон хэдий ч энэ нь 2014 оноос хойшхи хамгийн өндөр ажилгүйдлийн түвшинд тооцогдож байна.

2020 оны 10-р сарын байдлаар инфляцийн түвшин өмнөх сараас 0.08 хувиар өсч 4.09 хувьд хүрсэн нь 2019 оны 5-р сараас хойшхи хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Энэхүү өсөлтөд хоол хүнс болон согтууруулах бус ундааны үнэ голлон нөлөөлжээ.

Канад улс

Канадын эдийн засаг 2020 оны I улиралд 0.9 хувиар агшсан бол II улиралд дахин 13 хувиар агшиж түүхэндээ хамгийн муу үзүүлэлттэй хямралын үедээ орсон байна.

График 13. Канад улсын инфляци болон ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Tradingeconomics.com

Мөн 2020 оны 5-р сард тус улсын ажилгүйдлийн түвшин түүхэндээ хамгийн өндөр буюу 13.7 хувьд хүрсэн бөгөөд үүнээс хойш аажмаар буурсаар 10-р сард 8.9 хувьд хүрсэн байна.

Оны эхэнд харьцангуй тогтвортой 2.2 хувьтай байсан инфляцын түвшин 2-р сараас хойш аажмаар буурч 4 болон 5-р сард дефляцитай болсон бол 6-р сараас эхлэн инфляцитай болжээ.

ХАРЬЦУУЛАЛТ БА ДҮГНЭЛТ

Коронавируст цар тахал дэлхий дахинаа тарснаар нийт хүн төрөлхтний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт ноцтой цохилт үзүүлж ард иргэд болон олон улсын төр засгийн чадавхи чадамжийг шалгасаар байна. Энэ цаг үед манай Монгол Улс олон арга хэмжээ авсны дүнд цар тахал тархаж эхэлсэн үеэс хойш 10 гаруй сар тус вирусыг дотооддоо алдаагүй билээ. Гэсэн ч байдал илүү хүндэрч, нийт ард иргэдийн эрүүл мэндэд ноцтой заналхийлсэн энэ цаг үед бид бусад улс орны туршлагаас суралцах нь зүй ёсны юм. Улс орон бүрийн нөхцөл байдал болон авсан арга хэмжээ харилцан адилгүй ч бүхнийг шинээр санаачлан туршсанаас бусдын туршлагаас суралцан, шалгарсан аргыг өөрийн орны онцлогт нийцүүлэн ашиглах нь олон талын ач холбогдолтой.

Дараах хүснэгтэд сонгон судалсан улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эдийн засгийн өнцгөөс төсвийн бодлого болон мөнгөний бодлогын хүрээнд, хууль эрх зүй, улс төрийн өнцгөөс батлагдсан эрх зүйн акт, мөн төлөвлөгөөт сонгуулийг зохион байгуулсан эсэхээр харьцуулж харуулав.

Хүснэгт 3. COVID-19 цар тахлын үед улсуудын авч хэрэгжүүлсэн төсөв болон мөнгөний бодлогын ерөнхий харьцуулалт/Ази/

		Монгол Улс	Хятад (БНХАУ)	Сингапур (БНСУ)	Энэтхэг (БНЭУ)
ДНБ (өмнөх улиралтай харьцуулсан байдлаар)	I улирал	-10.7%*	-6.8%	-0.3%	3.1%
	II улирал	-9.7%*	3.2%	-13.3%	-23.9%
	III улирал	-7.3%*	4.9%	-7.0%	мэдээлэл байхгүй
Төсвийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн		1,5 их наяд төгрөг (нэмэлт санхүүжилт эхний 9 сараар)	6 их наяд юань	100 тэрбум сингапур доллар	ДНБ 7.2%
ДНБ 2019	тэрбумаар	36,898	99,087	508	203,848
ДНБ-ний хувь		4.1%	6.1%	19.7%	7.2%
Мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн		Бодлогын хүүг бууруулах	Заавал байлгах нөөц бууруулах	Овернайт зээлийн нөхцөлийг өөрчлөх	
		Заавал байлгах нөөц бууруулах	Зээлийн шугамын дүнг өсгөх Хүүгүй, барьцаагүй зээл олгох		Барьцаагүй зээл олгох
		Хэрэглээний зээлийн эргэн төлөлт хойшлуулах Зээлийн бүтцийн өөрчлөлт хийх	Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах Актив ангилалтыг өөрчлөх	Зээлийн эргэн төлөлтөд дэмжлэг үзүүлэх	Хувийн хэвшлээс бонд худалдан авах Актив ангилалтыг өөрчлөх
				Сургалтын зээлийг хойшлуулах	

				Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны хувийг бууруулах
Батлагдсан хууль, эрх зүйн акт	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай		Гэрээний үүргээ биелүүлэх чадамжгүй тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх ЖДҮ болон ТББ-д түрээсийн хөнгөлөлт үзүүлэх Санхүүгийн хямралд өртсөн хувь хүн, бизнест хөнгөлөлт үзүүлэх Барилгажилт хойшилсонтой холбоотой гэрээний хөнгөлөлт Багцын борлуулалт концессын арга хэмжээ COVID-19 вируст ноцтой өртсөн бизнесийн дахин хэлэлцээрийн тухай тус тус багтжээ.	Энэтхэгийн дотоод хэргийн яамнаас “COVID-19 цар тахалтай холбоотой нэдсэн удирдамж”
Сонгууль	УИХ-ын сонгууль 2020.6.24-ний өдөр орон нутгийн сонгууль 2020.10.15-ны өдөр хэвийн зохион байгуулагдсан.		2020.7.10-д улсын их хурлын сонгуулийг хэвийн зохион байгуулсан.	2020 онд нийт 3 сонгууль зохион байгуулахаар байсан ч бүгд хойшилсон.

1212.mn

Statista.com Tradingeconomics.com Tradingeconomics.com

*Улирлын ДНБ-ийн өөрчлөлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан болно.

Үргэлжлэл

COVID-19 цар тахлын үед улсуудын авч хэрэгжүүлсэн төсөв болон мөнгөний бодлогын ерөнхий харьцуулалт				
		Франц (БНФУ)	Испани (ИХУ)	Их Британи (ИБУИНХУ)
ДНБ (өмнөх улиралтай харьцуулсан байдлаар)	I улирал	-5.9%	-5.2% (P)	-2.5%
	II улирал	-13.8%	-17.8% (P)	-19.8%
	III улирал	18.7%	16.7% (P)	15.5%
Төсвийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн		676 тэрбум евро	170 тэрбум евро	567 тэрбум паунд
ДНБ 2019	тэрбумаар	2,426	1,245	2,170
ДНБ-ний хувь		27.9%	13.7%	26.1%
Мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн		Бодлогын хүү өөрчлөхгүй		Бодлогын хүүг бууруулах
		Урт хугацаат санхүүжилт		
		Бондын эргэн худалдан авалт		Бондын эргэн

			худалдан авалт Заавал байлгах нөөц бууруулах
Батлагдсан хууль, эрх зүйн акт	<p>Зарим татвар, төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг хойшлуулах, буцаах, хөнгөлөх заалтууд.</p> <p>Ажлын цагийг богиносгох, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгасан заалт.</p> <p>Хямралын үед хэрэглэгч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч зэрэг эдийн засгийн оролцогчдын маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх журам.</p>	<p>Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар яаралтай арга хэмжээ</p> <p>Эдийн засаг, нийгмийн нөлөөллийг арилгах онцгой яаралтай арга хэмжээ</p> <p>COVID-19 улмаас үүссэн эрүүл мэндийн гамшигт нөхцөл байдлаас түгшүүрийн байдлыг зарлах тухай</p> <p>Нөлөөг бууруулах ажлын байран дахь нэмэлт арга хэмжээ</p> <p>COVID-19-ийн эсрэг тэмцлийн хүрээнд хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилгоор зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлдэггүй ажил эрхэлж буй хүмүүст нөхөн төлөгдөх цалинтай чөлөө олгох</p>	COVID-19-тэй тэмцэх зорилгоор ажлын цагийг богиносгох, ажлын байрыг авч үлдэхтэй холбоотой заавар, дүрэм, хууль, мөн эдийн засгийг дэмжих, хүн амыг аюулаас хамгаалахтай холбоотой хууль зэрэг олон хууль
Сонгууль	2020.3.15-ны өдөр орон нутгийн сонгуулийн эхний шат зохион байгуулагдсан ч ирц 46%-тай байсан тул хоёр өдрийн дараа Францын Ерөнхийлөгч Макрон хоёр дахь шатны сонгуулийг хойшлуулсан.	Испанийн мужийн сонгууль 2020.4.5-ны өдөр болох байсан ч хойшлогдож 2020.7.12 өдөр болж өнгөрсөн	2020.3.13-ны өдөр болох байсан Английн орон нутгийн сонгууль, 2020.3.30-ны өдөр болох байсан Шотландын Орон нутгийн сонгууль хойшилсон

stats.oecd.org

stats.oecd.org

Statista.com

COVID-19 цар тахлын үед улсуудын авч хэрэгжүүлсэн төсөв болон мөнгөний бодлогын ерөнхий харьцуулалт				
		АНУ	Канад (КУ)	Мексик (МНУ)
ДНБ (өмнөх улиралтай харьцуулсан байдлаар)	I улирал	-5.0%	-2.1%	-1.2%
	II улирал	-31.4%	-11.5%	-17.0%
	III улирал	33.1%	10% (P)	12.1%

Төсвийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн	3 их наяд ам.доллар	708 тэрбум кан.доллар	ДНБ 0.7%
ДНБ 2019	21,430	2,304	24,239
ДНБ-ний хувь	14.0%	30.7%	0.7%
Мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн	Бодлогын хүү бууруулах Зээл олголтыг эрчимжүүлэх Бондын эргэн худалдан авалт Хувийн хэвшлээс өрийн бичиг худалдан авах Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг бууруулсан	Бодлогын хүү бууруулах Хувийн хэвшлийг дэмжих зээл олгосон Хувийн хэвшлээс өрийн бичиг худалдан авах	Бодлогын хүү бууруулах Заавал байлгах нөөц бууруулах Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны хувийг бууруулах
Батлагдсан хууль, эрх зүйн акт	Цалин хамгаалах төсөл, Эрүүл мэндийн хамгааллыг бэхжүүлэх акт Коронавирусийн эсрэг, эдийн засгаа хамгаалах акт /“CARES Act”/ COVID 19-ийн бэлтгэл хангах болон хангамжийн материал бэлтгэх акт Гэр бүлд дэмжлэг үзүүлэх акт		Кредит, урсгал зардал, санхүүгийн зах зээлийг дэмжихэд Тендерийн үйл явцыг хурдасгахад
Сонгууль	АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль 2020 оны 11 дүгээр сард хэвийн болж өнгөрсөн		

stats.oecd.org

bea.gov

stats.oecd.org

Монгол Улсын хувьд БНХАУ-ын туршлагаас суралцаж 2020 оны цагаан сарын баярын үеэр хөл хорио тогтоосон нь вирусны халдварыг даамжруулахгүй байх, тогтоон барих, сэргийлэхэд тустай оновчтой шийдэл байлаа. Түүнчлэн эрдэмтэн, шинжээчдийн зөвлөмжийн дагуу маскны хэрэглээг шаардаж, олон нийтийн газруудад биеийн халууныг хэмжих болсон нь эрсдэлийг эрс бууруулсан алхам байв. Харин зуны улиралд халдварлал, өвчлөлт намжин, хүмүүс нөхцөл байдалтай дасан зохицож байхад ДЭМБ-аас COVID 19-ийн хоёр дахь давлагааны талаар сануулж байсан билээ. Мутацид орсон вирустэй тэмцэхэд урьдын чангатгасан дэглэм шаардлагатайг ч сануулж байсан. Үүнийг үл ойшоон дэлхийн олон улс “эдийн засгийн уналт илүү олон хүний аминд хүрэх аюултай” хэмээн үзэж эдийн засгаа аврах зорилгоор хорио, цээрийг цуцалсан нь 8 дугаар сард олон улсад хоёр дахь давлагааг илүү ноцтой нөлөөлөхөд хүргэсэн юм. Судалгаанаас харахад энэ л өнцгөөс харж эдийн засгаа нээсэн орнуудын эдийн засгийн агшилт буурсан хэдий ч тархалт улам нэмэгдсэн

байдаг. Үүнээс гадна “хар хүний амь ч үнэтэй” жагсаал цуглаан АНУ болон Европын олон орнуудад хийгдсэн нь вирусын тархалтыг даамжруулсан.

Манай улсын хувьд мөн адил хоёр дахь давлагаа эхэлсэнээс хойш сонор сэрэмжээ бууруулсантай холбоотойгоор вирусны тархалтыг дотооддоо алдан, дахин хөл хорионы дэглэмд шилжээд байна.

Хууль эрх зүйн асуудлын хувьд хөгжингүй орнуудын адил олон хууль, эрх зүйн акт батлах шаардлагагүй байсан ч батлагдсан цөөн тооны баримт бичгийг хэрэгжүүлэхэд төрийн болон салбарын зохицуулагч байгууллагын уялдаа холбоо дутагдалтай байв. Тухайлбал, “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль 2020 оны 4 дүгээр сарын 29-нд батлагдаж эрүүл мэнд, нийгэм эдийн засгийн олон өнцгийг хөндөж чадсан ч, зарим заалт нь тодорхой бус, хэрэгжилтийн хувьд эргэлзээтэй байсанд тодруулга, тайлбар хийх нь удаан байснаас Монголбанкнаас арилжааны банкинд өгсөн чиглэл нь 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр буюу бүтэн сарын дараа ирж, зохиомол сандрал үүсгэж байсан юм.

Франц, Их Британи, Испани, Энэтхэг зэрэг орнуудад сонгуулийн үйл ажиллагааг хойшлуулсан ч манай орны хувьд АНУ, Сингапур зэрэг орнуудын адилаар Улсын их хурлын болон орон нутгийн сонгуулийг хэвийн зохион байгуулж өнгөрсөн. Энэ үед халдварыг дотооддоо алдаагүй байсан нь эерэг нөлөөтэй байв.

Манай улс дэлхийн ихэнх улсын жишгээр төсөв болон мөнгөний бодлогоор эдийн засгаа дэмжсэн нь авууштай ч АНУ, Канад, Их Британи, Франц, Испани, БНХАУ, Сингапур зэрэг орны адилаар тодорхой бүлгүүдэд хандан илүү нарийвчлах нь оновчтой байсан болов уу. Цаашид бизнес эрхлэгчдээ дампуурахаас хамгаалах, ажлын байрыг хадгалж үлдэх, байрны зээл, түрээсийн дэмжлэгийг ямар байдлаар аль болох хохирол багатай зохицуулах шаардлагатай байгаа зэрэгт чиглэсэн нарийвчилсан судалгааг шуурхай хийн, оновчтой шийдлийг хайх нь зүйтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Онцгой байдлын ерөнхий газар. <https://nema.gov.mn/c/resolution>

Эрүүл мэндийн яам. <https://covid19.mohs.mn/>

Хил хамгаалах ерөнхий газар. <http://bpo.gov.mn/content/624>

Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

Үндэсний статистикийн хороо. <https://1212.mn/>

Монгол банк. <https://www.mongolbank.mn/>

Сангийн яам. <https://mof.gov.mn/>

Азийн хөгжлийн банк. www.adb.org/

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. www.who.int

Deloitte in Singapore. (July 2020). *The impact of the COVID-19 and readiness for the new normal.* <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/sg/Documents/finance/sg-fa-local-industry-the-impact-of-covid-19-final-updated.pdf>

COVID-19 statistics for Asia. <https://www.covid19.onl/region/asia>

Government of Singapore.-Ministry of Social and Family development. *Support For Singaporeans Affected By COVID-19.* <https://www.msf.gov.sg/assistance/Pages/covid19relief.aspx>

Government of Singapore-Ministry of Finance. *Budget 2020-Budget measures.* https://www.singaporebudget.gov.sg/budget_2020/budget-measures

KPMG International Limited. (October 2020). *Singapore: Government and institution measures in response to COVID-19.* <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/singapore-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

KPMG International Limited. (October 2020). *China: Government and institution measures in response to COVID-19.* <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/china-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

KPMG International Limited. (October 2020). *India: Government and institution measures in response to COVID-19.* <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/india-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

IMF. *Policy Responses to COVID-19.* (November 2020). <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

IMF. (October 2020). *Fiscal Monitor Database of Country Fiscal Measures in Response to the COVID-19 Pandemic.* <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Fiscal-Policies-Database-in-Response-to-COVID-19>

Center for Strategic & International Studies. (November 2020). *Southeast Asia Covid-19 Tracker.* <https://www.csis.org/programs/southeast-asia-program/southeast-asia-covid-19-tracker-0>

Government of Singapore-Ministry of Law. (September 2020). Singaporean COVID-19 /temporary measures/ Act 2020 <https://www.mlaw.gov.sg/covid19-relief/>

Government of Singapore. (February 2020). Government Budget and Fiscal Position, Annual. <https://data.gov.sg/dataset/government-fiscal-position-annual>

Гадаад харилцааны яам- Консулын газар. <https://www.consul.mn/index.php?moduls=51>

Government of India- Ministry of Home affairs. CIRCULARS FOR COVID-19. <https://www.mha.gov.in/notifications/circulars-covid-19>

Coronavirus in India timeline: Tracking crucial moments of COVID-19 pandemic in the country. <https://indianexpress.com/article/india/coronavirus-covid-19-pandemic-india-timeline-6596832/>

International Foundation for Electoral Systems. (November 2020). Elections Postponed Due to COVID-19. https://www.ifes.org/sites/default/files/elections_postponed_due_to_covid-19.pdf

KPMG International Limited. (September 2020). France: Government and institution measures in response to COVID-19. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/france-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

KPMG International Limited. (October 2020). Spain: Government and institution measures in response to COVID-19. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/spain-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

KPMG International Limited. (November 2020). United Kingdom: Government and institution measures in response to COVID-19. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/united-kingdom-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

Bruegel Datasets. (November 2020). The fiscal response to the economic fallout from the coronavirus. <https://www.bruegel.org/publications/datasets/covid-national-dataset>

European Parliament. (September 2020). The ECB's Monetary Policy Response to the COVID-19 Crisis. [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2020/648787/IPOL_BRI\(2020\)648787_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2020/648787/IPOL_BRI(2020)648787_EN.pdf)

UK Parliament. (November 2020). Coronavirus: Economic impact. Briefing Paper (pp. 30-33). <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8866/>

“Policy responses to COVID-19” - <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

“How Ontario is responding Covid-19” <https://www.ontario.ca/page/how-ontario-is-responding-covid-19>

“Situation in Quebec” <https://www.quebec.ca/en/health/health-issues/a-z/2019-coronavirus/situation-coronavirus-in-quebec/>

“Coronavirus Disease COVID-19” <https://www.canada.ca/en/public-health/services/diseases/coronavirus-disease-covid-19.html>

“U.S. reports record Covid hospitalizations as states roll out restrictions ahead of Thanksgiving” - <https://www.cnbc.com/2020/11/14/us-reports-record-covid-hospitalizations-as-states-roll-out-restrictions-again.html>

“Coronavirus Second Wave? Why Cases Increase” - <https://www.hopkinsmedicine.org/health/conditions-and-diseases/coronavirus/first-and-second-waves-of-coronavirus>

The US Government. www.whitehouse.gov

Our world in data. www.ourworldindata.org

Centers for Disease Control and Prevention. www.cdc.gov

“Canada's COVID-19 hospitalizations and deaths likely to rise in coming weeks: Tam” - <https://www.nationalobserver.com/2020/11/05/news/canadas-covid-19-hospitalizations-and-deaths-likely-rise-coming-weeks-tam>

COVID tracking project. www.covidtracking.com

US Federal Reserve. www.federalreserve.gov

Worldometer – an independent developers and researchers. www.worldometers.info

US Bureau of Labor and Statistics. www.bls.gov